



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

**ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН**

**ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРГИЙГ ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ**

Бодлогын судалгааны тайлан

Гүйцэтгэсэн: Т.Түмэнцэцэг /Судалгаа хариуцсан референт/  
Э.Өсөхжаргал /Судлаач/

Гэрээт судлаачид:

П.Золзаяа /Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч/  
Ж.Оюунтунгалаг /Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч/  
Г.Алтанчимэг /Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч/

Хянасан: Э.Өлзийлхам /Судлаач, докторант/  
М.Туяа /ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын орлогч/  
Т.Мэндсайхан /ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, доктор/

Улаанбаатар хот  
2014 он

## Гарчиг

Хураангуй

Удиртгал

Нэгдүгээр бүлэг. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, дүн шинжилгээ

Хоёрдугаар бүлэг. Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн, хүчингүй болгосон процессийн зөрчил

Гуравдугаар бүлэг. Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон байдлыг маргааны төрлөөр ангилах нь

- 3.1. Гэрээний эрх зүйн маргаан
  - 3.1.1. Худалдах, худалдан авах гэрээ
  - 3.1.2. Зээлийн гэрээ
  - 3.1.3. Түрээсийн гэрээ
  - 3.1.4. Ажил гүйцэтгэх гэрээ
  - 3.1.5. Гэрээний бусад төрлүүд
- 3.2. Өмчлөх эрх, хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцох хэрэг, маргаан
- 3.3. Хөдөлмөрийн маргаан
- 3.4. Гэр бүлийн маргаан
- 3.5. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
- 3.6. Гэм хор
- 3.7. Өв залгамжлал
- 3.8. Бусад маргаан

Дүгнэлт

Санал, зөвлөмж

Ном зүй

Хавсралт

## Хураангуй

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс “Давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн шийдвэрийн үндэслэл, төрөл” сэдэвт судалгааны ажлыг 2014 оны 05 сарын 30-наас 09 сарын 5-ны хооронд Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаачид болон иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч нартай хамтран хийж гүйцэтгэлээ.

Судалгаагаар нийслэлийн хэмжээнд 2012, 2013 онд шийдвэрлэсэн иргэний хэргүүдээс Улсын Дээд шүүхээс болон Давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан шийдвэрүүдийг судалсан болно. Улсын дээд шүүхээр хянагдсан 573 хэргийг шийдвэр, магадлалын хамт цуглуулж, дүн шинжилгээ хийж, процессийн зөрчил болон хууль хэрэглээний нийтлэг алдаа, зөрчлийг илрүүлэн цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг боловсрууллаа.

Судалгааг “Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, дүн шинжилгээ”, “Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон үндэслэл, процессийн зөрчлүүд”, “Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон байдлыг маргааны төрлөөр ангилж нь” гэсэн гурван бүлэгт ангилж, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, чанарын статистик мэдээг танилцуулж, харьцуулалт, дүн шинжилгээг хийж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчихтэй холбоотой нийтлэг байдлаар илэрсэн зөрчлүүд, хууль хэрэглээ, хууль тайлбарлах явцад илэрсэн алдаа, зөрчлийн талаар нэгтгэн дурдаж, цаашид шүүгчдэд зайлшгүй шаардлагатай сургалтын чиглэлүүдийг санал болгов.

Шүүхийн шийдвэрийг судлахдаа гэрээний төрлөөр, өмчлөх эрх, хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хөдөлмөрийн эрх зүй, гэр бүлийн эрх зүй, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, гэм хор, өв залгамжлал болон бусад гэсэн ангиллаар тус тус төрөлжүүлэн дүн шинжилгээ хийлээ. Дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн шийдвэрийг хянаж, дүгнэлт гаргахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.2-т заасны дагуу “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх”<sup>1</sup> эрхтэй боловч зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянах ёстой байдаг. Шүүхийн шийдвэр хууль зүйн үндэслэлтэй, шударга ёсны зарчим, процессийн болон материаллаг эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн агуулга, хэлбэртэй байх ёстой. Иймд энэхүү судалгааг хийхдээ шүүгчийн хараат бус байдалд нөлөөлж болзошгүй тул ашигласан шүүхийн шийдвэрүүдэд шүүгчийн нэрийг дурдалгүй оруулсан болно.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль, ТМ №1, 1992

Судалгааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн шүүхийн шийдвэр хүчингүй болсон, өөрчлөлт орсон үндэслэлээр хамгийн өндөр үзүүлэлттэй, анхаарал татсан асуудал бол нотлох баримт үнэлэх, судлах, маргааны үйл баримтыг зөв тогтоох, нотлох баримтыг цуглуулах талаар хуульд заасан журам зөрчсөн алдаа илүүтэй гарч байна. Ингэхдээ нотлох баримтын адил хүчин чадал бүхий “шинжээчийн дүгнэлт”-ийг тал бүрээс нь бүрэн бодитой дүгнээгүй, оновчтой асуулт тавиагүй, шинжээчийн дүгнэлтийн үндэслэл бодитой бус байх зэрэг асуудлыг анхааралгүй хэргийг шийдвэрлэжээ.

Түүнчлэн зохигчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарт хэргийн материал, эрх үүргийг тайлбарлаж өгөөгүй, хурлын товыг зохих ёсоор мэдэгдэлгүйгээр хэргийг хянан шийдвэрлэсэн, нэхэмжлэлийн агуулгыг тодруулаагүй, сөрөг нэхэмжлэлийг авч хэлэлцэлгүйгээр шийдвэрлэсэн зэрэг зөрчлийн улмаас анхан шатны шүүхийн шийдвэр хүчингүй болох эсхүл өөрчлөлт орсон байна.

Шүүхийн шийдвэрийг судлахад өөр нэг анхаарвал зохих зүйл нь шүүхийн шийдвэрийн боловсруулалтыг сайжруулах асуудал юм. Шүүхийн шийдвэрийн бичилтээс харахад хэт товч, ойлгомжгүй байдлаар бичигдэж байна. Иймд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг зөв тогтоох, шийдвэрээ иргэдэд тодорхой, ойлгомжтой байдлаар хүргэх, шүүхийн шийдвэр бичих арга зүй, хуулийг тайлбарлан хэрэглэх ур чадварыг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Шүүхийн шийдвэрт өөрчлөлт орох, хүчингүй болоход шүүгчийн мэргэжил, ур чадвараас гадна хэргийн ачаалал, хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа зэрэг бусад хүчин зүйлс нөлөөлж байна гэж үзэх үндэслэлтэй. Тухайлбал, сум дундын шүүхийн шүүгч 2014 оны нэгдүгээр улиралд дунджаар 34 хэрэг, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгч дунджаар 16 хэрэг шийдвэрлэж байгаа бол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч дунджаар 57 хэрэг шийдвэрлэж байгаа нь нийслэл дэх иргэний хэргийн анхан шатны шүүгчдийн ачаалал өндөр байгааг харуулж байна<sup>2</sup>. Түүнчлэн 2013 онд нийслэлд анхан шатны шүүх 281 хэргийн үлдэгдэлтэй байсан нь өмнөх оноос 43 хэргээр буюу 18 хувийн өсөлттэй байна<sup>3</sup>. Иймд хэргийн ачаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа тухайн шүүгчийн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд алдаа гаргахад нөлөөлөхгүй гэж үзэх боломжгүй байна.

<sup>2</sup> Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүх эрх мэдэл” эмхтгэл, №2, 2014, 93-р хуудас

<sup>3</sup> Монгол Улсын шүүхийн тайлан, 2013.УБ., 82-р хуудас

Иймд судлаачдын зүгээс дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна:

1. *Шүүгчдэд хэрэгцээтэй сургалт зохион байгуулах;*

Судалгааны хүрээнд гарсан нийтлэг алдаа, зөрчлийн талаар нэгдсэн сургалт зохион байгуулахдаа хавсралтад байгаа материалын хүрээнд сургалтын хөтөлбөрийг боловсруулан үр дүнтэй сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна. Сургалтад материаллаг болон процессийн хуулийн хэрэглээг онолын мэдлэгтэй хослуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зохих ёсоор хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах сургалтын сэдвүүдийг санал болгож байна. Үүнд:

1. Процессийн сургалтын чиглэлээр:
  - Хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдөхөөс сэргийлэх.
  - Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг тогтоох, үнэлэх, шинжлэн судлах.
  - Хэрэг, маргааны үйл баримтыг зөв тогтоох.
2. Хууль хэрэглээний сургалтын чиглэлээр:
  - Хууль тогтоомжийн хэрэглээ.
3. Хууль зүйн техникийн сургалтын чиглэлээр:
  - Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангалттай, зөв тайлбарлах, шүүхийн шийдвэрийн бичилтийн ур чадварыг нэмэгдүүлэх.

Түүнчлэн шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий өргөн хүрээний мэдлэг, ур чадвар олгох, хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах хэрэгцээтэй байна. Сургалтын үр дүнд шүүгчид мэргэжил, арга зүй, практикийн ур чадвараа нэмэгдүүлэх юм.

2. *Шүүхийн шийдвэрийн алдаа, зөрчлийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх;*

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн дээрх зөрчлийн ойлголт, ангилалт одоогоор алга байгаа тул шүүгчид, судлаачдын зүгээс өөрийнхөөрөө тайлбарлах, нэрлэх байдал ажиглагдаж байна. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй зөрчлийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна. Ингэснээр шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарах алдааг тодорхойлж, уг алдааг аль болох багасгах, бууруулахад шат шатны шүүхээс анхаарч ажиллана.

3. *Хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох;*

Судалгаанаас үзэхэд шүүгчийн ачаалал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой байх тул цаашид хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй, үр нөлөөтэй болгох зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ нь шүүгчдийн гаргаж байгаа энгийн болон хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааны журам зөрчихтэй холбоотой зөрчлийг бууруулах, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой шийдвэрлэхэд ач холбогдолтой юм.

*4. Судалгааны ажлыг цаашид үргэлжлүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх;*

Шүүхийн шийдвэр шат шатандаа хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх, шийдвэрийн боловсруулалтыг сайжруулах, хуулийн зохицуулалтыг нэг мөр, зөв хэрэглэх явдлыг хангах, шүүгчдэд зориулсан сургалтын үр нөлөөг дүгнэх зорилгоор энэхүү судалгааг 2 жил тутам зохион байгуулах саналтай байна.

Зөрчлийн шинж байдлаас авч үзвэл энгийн утга найруулга, техникийн шинжтэй алдаанаас илүүтэйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчих, хууль хэрэглээний томоохон алдааг гаргаж байгаа нь энэ асуудлаар цаашид өргөн хүрээнд, зөрчлийн шинж чанар тус бүрээр судалж анхаарал хандуулах хэрэгтэй байна.

## Удиртгал

Шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлэх, агуулгын хувьд үр дүнд хүрэх нь шат шатны шүүхээс гарах шийдвэрүүд хоорондоо зөрүүтэй байх асуудлыг бууруулах, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг хангах явдал нь ихээхэн нөлөө үзүүлнэ.

Шүүхийн шийдвэр тогтвортой байх нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл байдаг тул гурван шатны шүүхийн шийдвэр хууль хэрэглээний болон процессийн зөрчилгүй нэгдмэл байх, хуулийг нэг мөр ойлгох явдлыг хангах нь чухал юм. Хэрэг, маргааны талаар материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилго, үзэл санаанд нийцүүлэн, шүүхээс оновчтой, зөв тайлбарлан хэрэглэсэн тохиолдолд шүүхийн шийдвэр хууль ёсны байх шаардлага хангагдана<sup>4</sup>. Өөрөөр хэлбэл зохигчид давж заалдаж, хяналтын шатанд гомдол гаргасан ч шийдвэрийн үндэслэл тогтвортой байж, иргэдийн шүүхэд итгэх итгэл хадгалагдана гэсэн үг.

Бидний судалгааны ажлын зорилго нь иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон шалтгаан, үндэслэлийг судалж, хууль хэрэглээ болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг алдаа, зөрчлийг олж тогтоох, дүн шинжилгээ хийх, цаашид шүүгчдийн давтан сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хууль хэрэглээний практикийг боловсронгуй болгох арга замыг санал болгоход оршино.

Судалгааг бие даасан хэлбэрээр явуулсан бөгөөд судалгааны дараах аргыг ашиглалаа. Үүнд:

- Баримт бичгийн судалгааны арга;
- Харьцуулалтын арга;
- Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга;
- Тохиолдол шинжлэх арга.

Судалгааны хүрээнд нийслэлийн хэмжээнд шийдвэрлэгдсэн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг хамруулсан бөгөөд маргааны төрлийн хувьд аль нэг сэдвийг сонгон судлах эсхүл нэг шийдвэрийг сонгон дүн шинжилгээ, судалгаа хийж байсан боловч өргөн хүрээнд хийгдсэн судалгаа, алдаа, зөрчлийг илрүүлсэн тайлан өнөөг хүртэл алга байгаа тул энэ судалгааны ажил шүүгчид, шүүхийн захиргааны ажилчид, эрх зүй судлаачдад ач холбогдолтой гэж үзэж байна. Цаашид сум дундын шүүхийн шийдвэрийг судлах, анхаарах асуудлыг гаргаж ирэх зайлшгүй

<sup>4</sup>Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол, “Шүүхийн шийдвэрийн тухай” 2006.04.24, Дугаар 21

шаардлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан болохыг дурдах нь зүйтэй болов уу.


Шат шатны шүүхийн шийдвэрийг судлахдаа анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэлийг судлахдаа хараат бус, бие даасан байдлаар зохион байгууллаа. Иймд та бүхнийг бидний хийсэн энэхүү судалгааны ажилтай танилцаж, шүүмж, санал зөвлөмжөө ирүүлэхийг хүсье.



## Нэгдүгээр бүлэг. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг сүүлийн 3 жилээр судалж үзэхэд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт орсон, хүчингүй болсон байдал өссөлттэй, анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэвээр үлдээж шийдвэрлэсэн байдал буурч байгаа нь Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон шалтгаан нөхцлийг судлах үндэслэл боллоо. Үүнийг графикаар үзүүлбэл:

График 1. Шийдвэрийн тогтвортой байдлыг графикаар харуулбал: /Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхийн магадлалаар өөрчлөлт оруулсан байдал, УДШ-ээр хянагдаагүй/



Давж заалдах шатны шүүх Монгол Улсын хэмжээнд 2011 онд 1803 хэрэг хүлээн авч шийдвэрлэсэнээс 973 шийдвэрийг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 54 хувийг хэвээр үлдээж, 440 шийдвэрийг буюу 24.4 хувьд өөрчлөлт оруулсан байна. Анхан шатны шүүхийн 390 шийдвэрийг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 21.6 хувийг хүчингүй болгожээ. Харин 2012 онд 1634 хэрэг хүлээн авч шийдвэрлэсэнээс 843 шийдвэрийг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 51.6 хувийг хэвээр үлдээж, 393 шийдвэрийг буюу 24 хувьд өөрчлөлт оруулж, 398 шийдвэрийг буюу 24.4 хувийг хүчингүй болгосон байна.

Түүнчлэн 2013 онд 1806 хэрэг хүлээн авч шийдвэрлэгдсэнээс 821 хэргийг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 45.5 хувийг хэвээр үлдээж, 492 шийдвэрийг буюу 27.2 хувьд өөрчлөлт оруулж, 493 шийдвэрийг буюу нийт 27.3 хувийг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгосон магадлал 2009 оноос тогтвортой буурч байсан боловч 2012 оноос 2013 онд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдсэн магадлал 25.2 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлал 23.8 хувиар тус тус өсчээ. Харин анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлал 2.6 хувиар буурсан байна. Эндээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөлт оруулсан магадлал өсч, хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлалын тоо буурч байгаа нь шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал буурч байгааг харуулж байна.

Хүснэгт 1. Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны шүүхийн тогтоолоор өөрчлөлт оруулсан байдал


Д/д	Төрөл	Жил		Өсөлт, бууралт		Жил		Өсөлт, бууралт	
		2011	2012	Тоо	Хувь	2012	2013	Тоо	Хувь
1.	Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн	544	454	-90	-16.5	454	465	11	2.4
2.	Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан	173	157	16	-9.2	157	154	3	-1.9
3.	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон	1	2	1	2 дахин	2	5	3	1.5 дахин
4.	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	11	20	9	81.8	20	8	-12	-60
5.	Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан	93	120	27	29	120	127	7	5.8
6.	<b>Шийдвэрлэсэн бүгд хэрэг</b>	<b>822</b>	<b>753</b>	<b>-</b>	<b>100</b>	<b>753</b>	<b>759</b>	<b>-</b>	<b>100</b>

Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шийдвэр 2011-2012 онд 90 хэрэг буюу 16.5 хувиар буурсан, 2012-2013 онд 11 хэргээр буюу 2.4 хувийн бага зэрэг өсөлттэй байна. Харин хүчингүй болгосон шийдвэр, магадлалын хувьд 2011-2012 онд 37 хэргээр буюу 35.2 хувиар өсч, 2012-2013 онд 2 хэргээр буюу 1.4 хувиар буурчээ. Хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн тоо өндөр, хүчингүй болсон тоо буурч байх нь шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал хангагдах үндэслэл болно.

Шүүхийн статистик маягтын дагуу давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийн хэдэн хувьд өөрчлөлт орсон, хүчингүй болсон, хэвээр үлдсэн талаарх мэдээлэл гардаг бол хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн

шийдвэр, магадлалын хэдэн хувьд нь өөрчлөлт орсон, хүчингүй болсон эсхүл хэвээр үлдсэн болохыг тус бүрд нь гаргаж харах боломжгүй тул шийдвэр, магадлалын тоон үзүүлэлтийг хамтад нь орууллаа.

График 2. Давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын шатны шүүхээс өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон, хэвээр үлдээсэн байдал



Давж заалдах шатны шүүхээс 2014 оны 1 дүгээр улиралд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн 168 шийдвэрийг хэвээр үлдээсэн нь нийт магадлалын 36.9 хувь, 139 шийдвэрт өөрчлөлт оруулсан нь 30.5 хувь, 148 шийдвэрийг хүчингүй болгосон нь 32.6 хувийг тус тус эзэлж байна. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн магадлалын эзлэх хэмжээ өмнөх оны 1 дүгээр улирлаас 8 хувиар буурсан, өөрчилсөн 1.5 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлалын эзлэх хэмжээ 6.6 хувиар тус тус өссөн<sup>5</sup> үзүүлэлттэй байх тул шүүхийн шийдвэр, магадлал өөрчлөгдөж, хүчингүй болж буй үндэслэл, шалтгааныг олж тогтоох, судлах, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

<sup>5</sup> Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Шүүх эрх мэдэл” эмхтгэл, 2014, №2, 94-р хуудас

## Хоёрдугаар бүлэг. Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэл, процессийн зөрчил

Хууль зүйн шинжлэх ухаанд Standard of review<sup>6</sup> буюу давж заалдах шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хууль ёсны дагуу хянах тухай ойлголт байх бөгөөд дараах байдлаар авч үздэг байна<sup>7</sup>.

1. De Novo Review-Доод шатны шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ хуулийг зөв хэрэглэсэн талаар өөрийн дүгнэлтийг хийх;  
Шүүхийн шийдвэрийг хянахдаа бүх асуудлыг эхнээс нь, шинээр хянах бөгөөд хэргийг шийдвэрлэхдээ хууль ёсны баримтанд тулгуурласан эсэх, хуулийг зөв тайлбарласан эсэх, эрх зүйн зарчмыг баримталсан эсэх, шийдвэрийн үндэслэл, шалтгаан нөхцлийг зөв тайлбарласан эсэхэд илүүтэй анхаардаг.
2. The Clearly Erroneous Standard of Review-Энгийн, ойлгомжтой алдааг хянах;  
Хэргийн үйл баримтыг хангалттай тогтоосон эсэх, нотлох баримтыг зөв тогтоосон эсэх асуудлыг анхаарч авч үздэг.
3. Review of Substantial Evidence-Чухал нотлох баримтыг хянах;  
Хэрэгт ач холбогдол бүхий чухал нотлох баримтыг зөв тогтоох, үнэлэх асуудалд анхаарна.
4. Review for Abuse of Discretion-Хэргийг өөрийн үзэмжээр шийдвэрлэсэн эсэхийг хянах;  
Шүүгчийн шийдвэр нэгдсэн стандартад нийцсэн эсэх, хууль тогтоомжийн алдаа гаргасан эсэхийг хянадаг байна.

Харин манай улсын хувьд давж заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-д заасан үндэслэлээр анхан шатны шүүх шийдвэрийг бүхэлд нь хянах онцгой эрхтэй бөгөөд тухайн шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх шаардлага тавигдана.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг ИХШХШТХ-д заасан үндэслэлээр хүчингүй болгоно. Харин шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай гэж шүүх бүрэлдэхүүн үзвэл ямар үндэслэлээр шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах болсон тухай бичиж, түүний хууль зүйн үндэслэлийг магадлалд тусгах нь шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой байх шаардлага хангагддаг.

Нэмэлт, өөрчлөлт гэдэгт найруулга, үг, үсгийн алдаа, тооны засвар орохоос гадна тогтоох хэсгийн зарим заалтыг бүхэлд нь өөрчлөх асуудал ч хамаарна. Шийдвэрийн зарим заалтыг хүчингүй болгоод оронд нь өөр заалт оруулсан тохиолдол мөн нэмэлт, өөрчлөлтөд хамаарах юм.<sup>8</sup>

Монгол Улсын хувьд ИХШХШТХ-ийн 167, 168 дугаар зүйлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг, 176 дугаар зүйлд заасан үндэслэлээр давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгох эсхүл өөрчлөлт оруулах эрхтэй. Харин хэрэг

<sup>6</sup> Black's law dictionary, Ninth edition, p-1535

<sup>7</sup> The Federal Circuit Bar Journal

<sup>8</sup> Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж. Давж заалдах шатны шүүхээс гарах магадлалын тухай. 2009, Дугаар 02

хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй алдаа, зөрчлийн талаар нэгдсэн ойлголт, ангилалт алга байна. Иймд энэхүү судалгаанд процессийн болон хууль хэрэглээний хувьд гарсан нийтлэг зөрчлийн шинж байдлаар ангилсан болно.

*Хүснэгт 2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг илэрч буй алдаа, зөрчлүүд*

	Процессийн зөрчлүүд	Тоо	Эзлэх хувь
1	Талуудын хооронд эрх зүйн харилцаа, маргааны үйл баримтыг буруу тодорхойлсон	16	7.5
2	Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодруулаагүй	35	16.5
3	Хэрэгт ач холбогдол бүхий хүсэлтийг шийдвэрлээгүй	7	3.3
4	Хөөн хэлэлцэх хугацааг буруу тодорхойлсон	1	0.4
5	Нотлох баримтууд ач холбогдолгүй гэж үзсэн үндэслэл нь тодорхойгүй, ойлгомжгүй, дутуу бүрдүүлсэн зэрэг нотлох баримтын үнэлгээтэй холбоотой асуудал	91	42.7
6	Зохигчдод хэргийн материал, эрх үүргийн зохих ёсоор танилцуулаагүй, хурлын тов мэдэгдээгүй	34	16
7	Улсын тэмдэгтийн хураамжийн талаар гаргасан хүсэлтийг шийдвэрлээгүй, буруу шийдвэрлэсэн	6	2.8
8	Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт хууль баримтлалгүй шийдвэрлэсэн	7	3.3
9	Үг үсэг, техникийн шинжтэй алдаа	6	2.8
10	Гуравдагч этгээдийн эрх ашиг, хэргийн оролцогчийг зөв тогтоогоогүй	6	2.8
11	Хууль бус бүрэлдэхүүнээр, эсхүл иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оруулаагүй хэргийг шийдвэрлэсэн	4	1.9
<b>12</b>	<b>Нийт</b>	<b>213</b>	<b>100</b>

Дээрх зөрчилд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн эсхүл үг, үсэг, утга найруулгын алдаа гаргасан шийдвэр аль аль нь агуулагдаж байна.

Тухайлбал, судалгааны хүрээнд илэрсэн нийтлэг зөрчлүүдийг авч үзэхэд нотлох баримтуудыг ач холбогдолгүй гэж үзсэн үндэслэл тодорхойгүй, ойлгомжгүй, дутуу бүрдүүлсэн зэрэг нотлох баримтын үнэлгээтэй холбоотой асуудлаар нийт 91 зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 42.7 хувийг эзэлж байна. Эндээс шүүгч нар нотлох

баримтыг үнэлж тогтоох, цуглуулж бэхжүүлэхэд гаргасан алдаа их байгааг харуулж байна.

Хэргийн оролцогчоос гаргасан нотлох баримтын үнэн зөв болохыг зөвхөн шүүх өөрийн дотоод итгэлээр үнэлдэг. Дотоод итгэл гэдэг нь хэрэгт цугларсан нотлох баримт үнэн зөв үнэлэгдэх, хэргийн бодит үнэнийг тогтооход чухал ач холбогдолтой, шүүх, шүүгчийн үзэл бодол, итгэл үнэмшил байдаг.<sup>9</sup> Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримт нь хуульд заасан журмын дагуу бэхжигдэж, гэрчлэгдсэн байхаас гадна хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр хэрэгт авагдсан байна.

График 3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг байдлаар илэрсэн процессийн зөрчлийг графикаар үзүүлбэл:



Үүнээс гадна шүүх нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодруулаагүй, сөрөг нэхэмжлэлийг үнэлээгүй гэх үндэслэлээр 35 хэрэг буюу нийт зөрчлийн 16.5 хувь, зохигчдод эрх, үүрэг, хэргийн материалыг танилцуулах, хурлын тов мэдэгдэх ажиллагааг зохих ёсоор хийгээгүй, баримтжуулаагүй гэх үндэслэлээр 34 хэрэг буюу 16 хувь байгаа нь өндөр үзүүлэлт юм.

<sup>9</sup> “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, УБ., 2014, 127 хуудас

**Жишээ нь: Сүхбаатар дүүргийн шүүхийн 2012 оны 05 сарын 28-ны 979 дүгээр шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 07 сарын 31-ний өдрийн 622 дугаар магадлал\***

**1. Хэргийн товч агуулга:**

Нэхэмжлэгч Э нь “Л.Т” ХХК-д холбогдуулан Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Чойжин ламын сүм музейн баруун талд байрлах “С.Р” ресторан байрлах 2 давхар барилгын В блокийн 44 хувийн хөрөнгө оруулагч, 1 дүгээр давхарын өмчлөгчөөр тогтоолгохыг хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагаас 44 хувь биш 42 хувьд хөрөнгө оруулалт хийснийг зөвшөөрч уг барилгын 1 давхрыг бүхэлд нь өмчлөгчөөр тогтоолгоно гэсэн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргаж, тус барилгын 1 дүгээр давхрын зүүн болон баруун хэсэгт зөвшөөрөлгүй барьсан өргөтгөлүүдийг буулгуулах сөрөг нэхэмжлэл гаргаж талууд маргажээ.

**2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:**

Анхан шатны шүүхээс:

Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, 476 дугаар зүйлийн 476.1, 478 дугаар зүйлийн 478.8-д заасныг баримтлан Э-г Сүхбаатар дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэр, Чойжин ламын сүм музейн баруун талд байрлах “С.Р” ресторан байрлах хоёр давхар барилгын 44 хувийн хөрөнгө оруулагч, “С.Р” рестораны зориулалтаар одоо эзэмшиж, ашиглаж буй В блокийн 1 дүгээр давхрын өмчлөгчөөр тогтоож, мөн барилгын давхрын зүүн болон баруун хэсэгт нэхэмжлэгч Э-ийн зөвшөөрөлгүй барьсан өргөтгөлүүдийг буулгуулахыг хүссэн сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

**3. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:**

Анхан болон давж заалдах шатны шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт цугларсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд эрх зүйн дүгнэлт өгч чадаагүйн зэрэгцээ хэрэг хянан

\* Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.



шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байна.

#### А. Нотлох баримт үнэлэх:

В блокийн 44 хувийн хөрөнгө оруулагчаар тогтоохдоо 2001 оны 06 сарын 10-ны өдрийн протокол, 2003 оны бүх хөрөнгө оруулагч нарын хуралдаж тооцоо нийлсэн 01/03 тоот протокол, 2004 оны хөрөнгө оруулалтын талаар шийдвэрлэсэн 01/04 тоот протокол, 2006 оны өмчлөлийн хувь хэмжээ тогтоосон протокол зэргийг тайлбартаа дурдсан хэдий ч 2001 болон 2004 оны протокол хэрэгт авагдсан байна. Түүнчлэн уг хоёр протоколд маргааны зүйл болж буй барилгад талууд 49, 51 хувиар хөрөнгө оруулалт хийх талаар дурдсан байхад нэхэмжлэлийн шаардлагад байгаа 44 хувь болон 1 дүгээр давхрын өмчлөгч болох талаар дурдаагүй байхад нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгон шийдвэрлэсэн байна.

Аудитын газрын шинжээчийн шийдвэрийг үндэслэл болгон хэргийг шийдвэрлэсэн байх бөгөөд тэрхүү аудитын газрын шинжээчийн дүгнэлтэд дээр дурдсан 3 протоколыг үндэслэл болгон дүгнэлт гаргажээ. Энэ нь шүүхийн шийдвэрийг анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргах, шийдвэрийн үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заах ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.3, 118 дугаар зүйлийн 118.4-т заасан шаардлагуудыг хоёр шатны шүүх бүрэн хангаж чадаагүй байна.

Хууль зөрчиж барьсан барилгын өргөтгөлийг буулгуулах буюу газар чөлөөлүүлэх агуулга бүхий шаардлагыг гаргасан сөрөг нэхэмжлэлийг хариуцагч гаргах эрхгүй, харин газрын асуудал хариуцсан эрх бүхий этгээд гаргах ёстой гэсэн шүүхийн дүгнэлт нь ИХ-ийн 91, 92 дугаар зүйлийн холбогдох заалттай нийцсэн гэхэд учир дутагдалтай юм.

Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн шинжээчийн 051 дүгээр дүгнэлтээр нэхэмжлэгчийн оруулсан хөрөнгийн хэмжээг өмнөх шинжээчийн дүгнэлтээс үнийн дүнг багаар тогтоосон бөгөөд уг шинжээчийн дүгнэлтийг заавал баримтлах албагүй гэж дүгнэсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд үндэслэл бүхий дүгнэлт өгсөн гэж үзэх боломжгүй юм.

Хариуцагчийн итгэмжлэгчийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүнийг татгалзсан хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэнээ давж заалдах шатны шүүх түүнд танилцуулаагүйгээс гадна 2012 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн шүүх хуралдааны товыг өмнөх өдөр нь буюу 7 сарын 30-ны өдөр Сүхбаатар аймагт байхад мэдэгдсэн



нь шүүх хуралдаанд оролцох боломжоор хангаагүй байх ба түүнчлэн шүүх хуралдааныг шөнийн цагаар хийх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллаганы журам зөрчсөн алдаа, зөрчлүүд гаргажээ.

Б. Утга найруулга, техникийн шинжтэй алдаа:

Шүүх хуралдаанд зөвхөн нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч оролцсон бөгөөд шүүх хуралдааны тэмдэглэлд тэдгээр нь шүүх бүрэлдэхүүнийг татгалзахгүй гэснийг тусгасны дараа “оролцогчид шүүх бүрэлдэхүүнийг татгалзсан” гэсэн нь техникийн шинжтэй алдаа хэдий ч уг тэмдэглэлийн үнэн зөв байдалд харш болсныг дурдах нь зүйтэй юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн дээрх зөрчлийн талаар нэгдсэн ойлголт, ангилалт одоогоор байхгүй боловч судалгааны хүрээнд илүү ойлгомжтой байх үүднээс илэрсэн зөрчлийн шинж байдлаар авч үзлээ. Нийтлэг илэрч буй дээрх зөрчлүүд нь ИХШХШТХ-ийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх шаардлагатай байгааг харуулж байна.


Зөрчлийн шинж байдлаас авч үзвэл энгийн утга найруулгын алдаанаас илүүтэйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчих тодруулбал тухайн шийдвэрийг хүчингүй болгох хэмжээний томоохон алдааг гаргаж байгаа нь энэ асуудлаар цаашид өргөн хүрээнд, зөрчлийн шинж чанар тус бүрээр судалж анхаарал хандуулах хэрэгтэйг харуулж байна.

## Гуравдугаар бүлэг. Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон байдлыг маргааны төрлөөр ангилах нь

### 3.1. Гэрээний эрх зүйн хэрэг, маргаан

Гэрээний эрх зүйн маргаанд зээлийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, түрээсийн гэрээтэй холбоотой маргаан дийлэнх хувийг эзэлж, шийдвэрлэгдэж байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График 4. Гэрээний маргааныг шийдвэрлэсэн байдал



Иргэний хэрэг, маргаан 2012 онд 27792 хэрэг шийдвэрлэгдсэн бөгөөд үүнээс 5243 хэрэг буюу 18.8 хувийг гэрээний эрх зүйн маргаан эзэлж байсан бол 2013 онд 35314 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэснээс 7022 хэрэг буюу 19.8 хувийг гэрээтэй холбоотой маргаан эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулбал 1 хувиар өссөн үзүүлэлт юм.

Гэрээг тодорхойлсон ойлголтуудыг гэрээний эрх зүйн сурах бичиг, нэг сэдэвт бүтээлүүдээс эрх, үүрэг үүсгэх тухай тохиролцоо, тохиролцооны агуулгыг нь нотлох баримт бичиг гэдэг талаас нь ойлгосон байдаг.<sup>10</sup> Иргэний хуулийн гэрээний эрх зүйн бүл нь бүхэлдээ үүргийн харилцаа үүсгэхэд чиглэдэг. Гэрээ хоёр талын, заримдаа түүнээс олон талын хүсэл зоригийн нэгдэл байдаг<sup>11</sup> бөгөөд хэлбэрийн хувьд агуулга, зохицуулалт, нийтлэг байдлаас хамаарч олон төрлүүдэд ангилагдана. Гэрээг зөвхөн гадна нэршлээр бус тухайн гэрээний агуулга, зохицуулж буй харилцааны шинж чанараас хамаарч тодорхойлно.

<sup>10</sup>Ж.Оюунтунгалаг, “Харьцуулсан иргэний эрх зүй” 2013, УБ., 112-р хуудас

<sup>11</sup>Б.Буянхишиг, “Иргэний эрх зүйн тусгай анги”, 2013, УБ., 23-р хуудас

Хүснэгт 3. Гэрээний эрх зүйн маргааныг шийдвэрлэсэн байдал

Д/д		Бүтэн жил		Өсөлт, бууралт		Нийт хэрэгт эзлэх хувь	
		2012	2013	Тоо	Хувь	2012	2013
1	Худалдах, худалдан авах гэрээ	2096	3257	1161	55.4	40	46.4
2	Зээлийн гэрээ	2293	2823	530	23.1	43.7	40.2
3	Түрээсийн гэрээ	180	238	58	32.2	3.4	3.4
4	Ажил гүйцэтгэх гэрээ	355	306	-49	-13.8	6.8	4.4
5	Хөлсөөр ажиллах гэрээ	98	115	17	17.3	1.9	1.6
6	Хамтран ажиллах гэрээ	76	86	10	13.1	1.4	1.2
7	Бусад	145	197	52	35.9	2.8	2.8
8	Нийт	5243	7022				

Гэрээний эрх зүйн маргаанд 2013 онд худалдах, худалдан авах гэрээ өмнөх оноос 55.4 хувиар, зээлийн гэрээ 23.1 хувиар, түрээсийн гэрээ 32.2 хувиар тус тус өссөн, харин ажил гүйцэтгэх гэрээ өмнөх оноос 49 хэргээр буюу 13.8 хувиар буурсан байна.

Шүүгчдийн хувьд нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодруулаагүйгээс гэрээний агуулгыг буруу ойлгох, хуулийн зүйл, хэсгийг буруу баримтлан шийдвэрлэж байна. Иймд гэрээний маргааныг хянан шийдвэрлэхэд илэрсэн зөрчлийг гэрээ тус бүрээр нь дараах байдлаар ангилан үзүүлье.\*

*Худалдах, худалдан авах гэрээнд дараах хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- Зохигчийн хооронд үүссэн маргаан, гэрээнээс татгалзах ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1-д заасан гэрээнээс татгалзах агуулгатай байхад шүүх гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй хариуцлага болох алданги гаргуулахаар шийдвэрлэсэн нь 232 дугаар зүйлийн 232.6-д заасан “хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ” гэсэн зохицуулалттай нийцээгүй;
- Худалдан авсан хөрөнгө доголдолтой байхад шаардлага гаргах эрхээ алдсан байсныг зөв тогтоогоогүй, ИХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1-д заасныг тогтоолгүй буруу тайлбарласан;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортолсон болон экспортолсон этгээд,

\* Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.

түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна” гэсэн заалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн;

- ИХ-ийн 225 дугаар зүйлийн 225.1-д зааснаар талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бөгөөд үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч үр дүн гараагүй бол нөгөө тал гэрээнээс татгалзах эрхтэй гэх нөхцөл байдал тогтоогдож байгааг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1-д нэхэмжлэлийн шаардлагад хамааралтай хуулийн заалтыг оновчтой хэрэглээгүй;
- ИХ-ийн 234 дүгээр зүйлийн 234.1 “Үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар гуравдагч этгээд үүрэг гүйцэтгэгчид баталгаа гаргаж болно”, 221 дүгээр зүйлийн 221.3-д заасан гэрээ цуцлах хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Хууль тогтоомжийн дагуу хувь хүн, хуулийн этгээдийн орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ” гэсний хууль зүйн үндэслэлгүйг анхааралгүй, гэрээний заалтыг үндэслэл нотолгоогүйгээр үгүйсгэсэн;
- ИХ-ийн 63 дугаар зүйлийн 63.2-т зааснаар төлөөлөгч төлөөлүүлэгчээс олгосон бүрэн эрхийн хүрээнд, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бөгөөд уг хэлцлээс үүсэх эрх, үүрэг нь гагцхүү төлөөлүүлэгчид бий болох байтал хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- ИХ-ийн 157 дугаар зүйлийн 157.1-д заасан барьцаалагчийн эрх үүсээгүй байхад хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн;

**Жишээ нь: Баянзүрх дүүргийн шүүхийн 2011 оны 09 дүгээр сарын 22-ны 2047 дугаар шийдвэр**

**1. Хэргийн товч агуулга:**

“Х.Х” ХХК нь нэхэмжлэгч Э-с автомашин худалдан авахаар болж, төлбөрийг хэсэгчлэн төлөхөөр тохиролцжээ. 2009 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төлбөрийг төлж чадахгүй бол 42000 ам.доллар болон сард 3 хувийн хүү төлөхөөр тохирчээ. Уг хугацаанд төлбөрөө бүрэн төлж барагдуулаагүй учраас нэхэмжлэгч Э хариуцагчаас 56023 ам.доллар гаргуулахаар шүүхэд хандсан байна.

Хариуцагч “Х.Х” ХХК нь нэхэмжлэгч Э-н зарсан “Волкесваген” маркийн автомашин нь 2007 оных биш 2005 оны машин байсан. Иймээс хуурч мэхэлсэн, худалдах худалдан авах гэрээг бичгээр байгуулаагүй тул хүү төлөх боломжгүй гэж үзэж, сөрөг нэхэмжлэл гаргасан байна.

## 2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

### Анхан шатны шүүхээс:

ИХ-ийн 243 дугаар зүйлийн 243.1-д зааснаар “Х.Х” ХХК-иас худалдах, худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд 69.412.497 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

### Давж заалдах шатны шүүхээс:

Баянзүрх дүүргийн шүүхийн 2011 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 2047 дугаар шийдвэрийг “Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 222 дугаар зүйлийн 222.5-д зааснаар хариуцагч “Х.Х” ХХК-иас 32086 ам.доллар буюу 40.460.446 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Э-д олгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн Иргэний хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 254 дүгээр зүйлийн 254.6-д зааснаар зохигчдын хооронд үйлдсэн 2008 оны 11 сарын 19-ний өдөр байгуулсан автомашин худалдах, худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах, гэрээгээр өгсөн, авснаа буцаан гаргуулахыг хүссэн хариуцагч “Х.Х” ХХК-ийн гаргасан сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

### Хяналтын шатны шүүхээс:

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 880 дугаар магадлалд “Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 222 дугаар зүйлийн 222.5-д зааснаар хариуцагч “Х.Х” ХХК-иас 32086 ам доллар буюу 40.460.446 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Ж-д олгосугай” гэснийг “...Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 222 дугаар зүйлийн 222.5-д зааснаар хариуцагч “Х.Х” ХХК-иас 32086 ам.доллар буюу 40.460.446 төгрөг гаргуулж нэхэмжлэгч Э-д олгож, нэхэмжлэлээс 28.952.051 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчлөлт оруулсан байна.

## 3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:

Анхан шатны шүүхийн шийдвэр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.2-т заасан “Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэсэн хуулийн шаардлагыг хангаагүй байна.

### А. Хууль хэрэглээний алдаа

Нэхэмжлэгч Э нь хариуцагч “Х.Х” ХХК-д холбогдуулан автомашин худалдах, худалдан авах гэрээний үүрэгт 69.412.497 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн бөгөөд Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 234.1-д зааснаар нэхэмжлэгч шаардах эрхтэй юм.

Хэрэгт авагдсан баримтуудаас үзэхэд нэхэмжлэгч Э нь 2008 оны 11 сарын 19-ний өдөр хариуцагч “Х.Х” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж, 27-28 УБП

улсын дугаартай, Волкесваген Туарег /Volkesvagen Touareg/ маркийн автомашиныг 42000 ам.доллараар худалдан авахаар тохиролцсон нь талуудын тайлбар болон хэрэгт авагдсан “Баталгаа бичиг” зэрэг баримтаар тогтоогдож байна.

Хариуцагч шүүхэд гаргасан хариу тайлбартаа “...2009 оны 4-р сард мөнгөний хэрэгцээ гарч автомашиныг барьцаанд тавих болоход уг автомашиныг 2007 онд биш 2005 онд үйлдвэрлэгдсэн болохыг мэдэж, нэхэмжлэгчид автомашиныг буцаан авах, эсхүл үнэ бууруулахыг шаардсан” гэж тайлбарласан ч ИХ-ийн 254 дүгээр зүйлийн 254.6-д “...тухай эд хөрөнгийг шилжүүлэн авснаас хойш 6 сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргана” гэж заасан бөгөөд хариуцагч 2009 оны 4 сард доголдолтой эд зүйл худалдан авсан болохоо мэдсэн боловч гомдлын шаардлага гаргах хуульд заасан эрхээ алдсан гэж үзэх үндэслэлтэй байна.

*Зээлийн гэрээнд дараах хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- ИХ-ийн 216 дугаар зүйлд заасан Үүрэг гүйцэтгэх дарааллыг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Гэрээний хүчин төгөлдөр байдлын талаар дүгнэлт өгөөгүй, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан хэлцлээс үүсэх үр дагаврыг 56.5-д зааснаар арилгах үүрэгтэй байтал ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1-д зааснаар үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзсэн нь хууль хэрэглээний хувьд алдаатай;
- Торгууль, алдангийн алийг нь төлөх талаар гэрээгээр тохирсон нь тодорхойгүй байхад алданги гаргуулж, ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.6-д заасныг зөрчсөн;
- Хүү тогтоосон гэрээг бичгээр хийх ИХ-ийн 282 дугаар зүйлийн 282.3-д заасныг анхаараагүй хүү гаргуулсан;
- Зохигч амаар байгуулсан гэрээгээ, хожим нь бичгийн хэлбэрт оруулж хүүгийн хэмжээг өөрчилж, хугацаа тохирч сунгасныг үндэслэлгүй гэж үзсэн шүүхийн дүгнэлт ИХ-ийн 281 дүгээр зүйлийн 281.1, ИХ-ийн 282 дугаар зүйлийн 282.2-д заасантай нийцээгүй;
- Шүүх нэхэмжлэлийн үндэслэл болж буй зээлийн гэрээгээр шаардах эрх үүсэхгүй, энэхүү гэрээгээр мөнгө шилжүүлсэн нь нотлогдоогүй байхад шүүх зохигчийн хооронд зээлийн гэрээ байгуулагдсан гэж үзсэн ИХ-ийн 281 дүгээр зүйлийн 281.1, ИХ-ийн 186 дугаар зүйлийн 186.1, ИХ-ийн 196 дугаар зүйлийн 196.1.1-д заасантай нийцээгүй, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болж буй зээлийн гэрээгээр шаардах эрхгүй гэж үзсэн атлаа өөр гэрээний дагуу мөнгө төлөх үндэслэлтэй гэж нэхэмжлэлийн шаардлагаас хальж хэргийг шийдвэрлэсэн;

- ИХ-ийн 281 дүгээр зүйлийн 281.1-д заасан зээлийн гэрээний зохицуулалтыг хамтран үүрэг гүйцэтгэгчийн буюу 242 дугаар зүйлтэй харьцуулалгүй буруу тайлбарлан хэрэглэсэн;
- ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1, ИХ-ийн 453 дугаар зүйлийн 453.1-д зааснаар зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд зээлийн гэрээг бичгээр хийх хуулийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт өгөөгүй, зээл олгогдох үед тухайн байгууллага үйл ажиллагаа явуулж байсан эсэхийг тодруулаагүй, зохигчийн хооронд үүссэн маргааны төрлийг зөв тодорхойлж чадаагүй;
- ИХ-ийн 453 дугаар зүйлийн 453.1-д зааснаар зээлдэгч авсан зээлээ хугацаандаа төлөөгүй бол түүнээс хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүү шаардах эрхтэй байхад шинэ гэрээ байгуулах нэрийдлээр хүүгээс хүү тооцох хууль зүйн үндэслэлгүйг шүүх анхаараагүй, зохигчийн хооронд байгуулагдсан зээлийн гэрээг өмнөх зээлийн гэрээтэй холбож үзээгүй зэргээр хуулийг буруу хэрэглэсэн;
- Зохигч зээлээ хугацаандаа төлөөгүй бол алданги төлүүлэхээр тохирсон байхад хүү тооцох ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.5-д заасан зохицуулалтыг баримталж шийдвэрлэсэн нь хууль хэрэглээний хувьд алдаатай;
- ИХ-ийн 123 дугаар зүйлийн 123.6-д зааснаар шаардах эрх шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжихэд хүү, алданги төлүүлэхээр шаардах эрхгүй гэж үзсэн нь буруу;
- Зээлийн үүргийн гүйцэтгэлийг талийгаачийн өвөөс тэргүүн ээлжинд хангуулах үндэслэлтэй байхад ИХ-ийн 461 дүгээр зүйлийн 461.2-т зааснаар шууд батлан даагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн нь хуульд нийцээгүй;
- ИХ-ийн 76, 77, 78 дугаар зүйлд буруу тайлбарлаж, хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон гэж дүгнэсэн нь хуулийн зохицуулалтыг хэрэглэсэн;
- Түүнчлэн шүүх гэрээний харилцаанаас үүсэх маргааныг шийдвэрлэхдээ зайлшгүй хийвэл зохих эрх зүйн дүгнэлтийг хийгээгүй, хэргийн бодит байдлыг бүрэн тогтоогоогүй байхад хэргийг шийдвэрлэсэн, зохигчийн хооронд байгуулагдсан удаа дараагийн зээлийн гэрээ, түүний үүргийн биелэлтийг нарийн зааглан тогтоож, тооцоо хийгээгүй зэрэг нийтлэг алдаа, зөрчлүүд гарчээ.

**Жишээ нь: Сонгинохайрхан дүүргийн 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 862 дугаар шийдвэр**

*1. Хэргийн товч агуулга:*

Хариуцагч А нь 2012 оны 01 сарын 31-ний өдөр нэхэмжлэгч М-ээс 25.000.000 төгрөгийг 3 сарын хугацаатай сарын 8 хувийн хүүтэй, мөнгийг хувааж төлөхөөр тохиролцон гэрээ байгуулжээ. Гэрээнд заасан хугацаанд А нь үндсэн зээл 25.000.000 төгрөг, хүү 6.000.00 төгрөг, нийт 31.000.000 төгрөг төлөх ёстойгоос хугацаандаа



2.000.000 төгрөг, хугацаа хэтрүүлж 2012 оны 5 сард 2.300.000 төгрөг, 6 сард нь 2.500.000 төгрөг, 10 сард нь 35.000.000 төгрөг нийт 41.800.000 төгрөг төлсөн байна. Харин нэхэмжлэгчийн зүгээс зээлийн гэрээ сунгагдсан тул 35.000.000 төгрөг авахаас амьдралын байдлыг нь харгалзан үзээд 11.100.000 төгрөг гаргуулахаар шүүхэд ханджээ.

Хариуцагч А-н хувьд зээлийн гэрээний үүрэгт илүү төлсөн 4.500.000 төгрөгийг нэхэмжлэгчээс гаргуулах сөрөг нэхэмжлэл гаргаж, талууд маргажээ.

## *2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

### Анхан шатны шүүхээс:

Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1, 282 дугаар зүйлийн 282.3, 282.4, 232 дугаар зүйлийн 232.4-т зааснаар хариуцагч А-аас зээлийн гэрээний үүрэг, үндсэн зээл, хүү алдангийн хамт нийт 11.000.000 төгрөг гаргуулан нэхэмжлэгч С-д олгож, зээлийн гэрээний үүрэгт илүү төлсөн 4.500.000 төгрөг гаргуулах сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

### Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн “... Иргэний хуулийн 282.3, 282.4-т зааснаар...” гэснийг хасч, “Иргэний хуулийн 282.1, 232.6-т зааснаар” гэж нэмж, “...А-с 11.100.000 төгрөг гаргуулан нэхэмжлэгчид олгосугай” гэснийг “...3.700.000 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгож, 7.400.000 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчлөлт оруулжээ.

### Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

## *3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

### *А. Хууль хэрэглээний алдаа:*

Хуульд зааснаар хүү тогтоосон зээлийн гэрээг бичгээр байгуулах ёстой бөгөөд зохигчдын хооронд гэрээг сунгах талаар хүсэл зоригоо илэрхийлж тохиролцсон бичгийн хэлцэл байхгүй тул ИХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т зааснаар гэрээг сунгагдсан гэж үзэх боломжгүй юм.

Хариуцагч А нь 2012 оны 01 сарын 30-ны өдрийн зээлийн гэрээний дагуу 31.000.000 төгрөгийг 3 сарын хугацаанд төлөх ёстой байсан боловч гэрээний хугацаанд 2.000.000 төгрөгийг төлсөн байна. Талуудын байгуулсан зээлийн гэрээний 3 дугаар зүйлд зааснаар “...зээлийг эргүүлэн төлөх хугацааг хэтрүүлсэн хоног тутамд



гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлөхөөр шаардах эрхтэй” гэж заасны дагуу зээлийн гэрээний үлдэгдэл болох 29.000.000 төгрөгөөс алданги гаргуулах эрхтэй юм.

Иймд зээлийн гэрээний үүргийн биелэлт болох төлөгдөөгүй төлбөр 31.000.000 төгрөг үүнээс хугацаа хэтрүүлсэн төлбөр болох 29.000.000 төгрөгөөс алдангийн зохицуулалт болох Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.4, 232.6-д заасантай нийцүүлж гүйцэтгээгүй үүргийн 50 хувиар тооцож, 14.500.000 төгрөг, нийт 45.500.000 төгрөгийг хариуцагч төлөх үүрэгтэй ба түүний төлсөн 41.800.000 төгрөгийг хасч 3.700.000 төгрөгийг хариуцагч А-аас гаргуулах нь зүйтэй юм.

Анхан шатны шүүхээс зохигчдын хооронд байгуулсан зээлийн гэрээг сунгагдсан гэж дүгнэж зээлийн төлбөрийн үлдэгдэл 11.100.000 төгрөгийг хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн нь хууль хэрэглээний алдаатай шийдвэр байна.

*Түрээс, эд хөрөнгө хөлслөх гэрээнд хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- ИХ-ийн 289 дугаар зүйлийн 289.2.1-д зааснаар хөлслөгчийн буруугүйгээр хөлслөн авсан эд хөрөнгө ашиглах боломжгүй болсон бол хөлс төлөхөөс татгалзах эрхтэй байтал хуулийн заалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3, 318.4-т заасан үндэслэлээр түрээсийн гэрээтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон;
- ИХ-ийн 232 дугаар зүйлийн 232.6-д зааснаар гэрээнд заасны дагуу хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр анз төлөх байтал хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн;
- ИХ-ийн 234 дүгээр зүйлийн 234.4-д зааснаар үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол түүний зохих ёсоор гүйцэтгэх үүргийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардах эрхтэй гэсэн хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- ИХ-ийн 289 дүгээр зүйлийн 289.2.5-д заасны дагуу хөлслөгч нь хөлслүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр өөрийн зардлаар хөлслөн авсан эд хөрөнгийг өөрийн зардлаар засч сайжруулсан бол төлбөрийг хөлслүүлэгчээс шаардах эрхтэй гэсэн зохицуулалтыг баримтлан шийдвэрлэсэн нь үндэслэл муутай, шаардах эрх нь бүрэн хангагдаагүй байхад хэргийг шийвэрлэсэн;
- Түрээсийн гэрээг дуусгавар болсноос эд хөрөнгийг буцаан шилжүүлэх үүргийг биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг шаардах эрх нь ИХ-ийн 295 дугаар зүйлийн 295.4 дэх хэсэгт заагдсан байхад иргэний хуулийн ерөнхий зохицуулалт болох 227 дугаар зүйлийн 227.1-г баримтлаагүй байна;
- Гэрээнээс татгалзсантай холбоотой маргаанд түрээсийн гэрээний зохицуулалт 318 дугаар зүйлийн 318.1-д зааснаас гадна 205 дугаар зүйлийн 205.1-г баримтлаагүй байна;

- Зөвшөөрөлгүйгээр түрээсийн зүйлийг дамжуулан түрээслэсний улмаас гэрээг цуцалсантай холбоотой маргаанд ИХ-ийн 318 дугаар зүйлийн 316.1, 323 дугаар зүйлийн 323.1 дэх хэсгийг баримтлалгүй ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтыг баримталж түрээсийн гэрээг үргэлжлүүлэхийг шаардсан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон;
- Түрээсийн гэрээг бичгээр байгуулах тухай ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.4 дэх хэсэгт заасныг анхаараагүй боловч бусдын байранд гэрээний дагуу тодорхой үйл ажиллагаа явуулж байсан бол ИХ-ийн 318.2, 287.1 дэх хэсэгт заасан эд хөрөнгө ашигласан хөлсийг гаргуулах ёстой;

**Жишээ нь: Хан-Уул дүүргийн 2013 оны 4 сарын 8-ны өдрийн 552 дугаар шийдвэр**

*1. Хэргийн товч агуулга:*

Нэхэмжлэгч Н Түрээсийн гэрээ байгуулан Т-н өмчлөлийн орон сууцыг 3 жилийн хугацаатай, сард 2 сая төгрөгийн түрээс төлөхөөр, аж ахуйн зориулалтаар ашиглахаар тохиролцон гэрээ байгуулжээ. Түрээсийн гэрээний 5 сарын төлбөрт 10 сая төгрөг, барьцаанд 2 сая төгрөг төлсөн бөгөөд 5 сарын хугацаа дууссаны дараа түрээсийн төлбөр нэмэгдэж, байр, цахилгааны төлбөр нэмж авахаар болсныг Т амаар мэдэгджээ. Хэрвээ энэ шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол байрыг суллаж өгөхийг Т шаардсан байна. Улмаар Н энэхүү шаардлагыг зөвшөөрөлгүй, Т-тэй маргалдаж Н-ийн биед гэмтэл учруулжээ. Иймд нэхэмжлэгч Н эмчилгээ хийлгэсэн төлбөр болох 2 сая төгрөг, түрээсийн гэрээ цуцалснаас учирсан хохирол буюу олж болох байсан орлого 8 сая төгрөг, нийт 10 сая төгрөгийг Т-ээс нэхэмжилж шүүхэд ханджээ.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

Анхан шатны шүүхээс ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3, 318.4, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар Түрээсийн гэрээг бичгээр байгуулах, үл хөдлөх эд хөрөнгийн газар бүртгүүлэх гэсэн шаардлагыг хангаагүй тул гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэж, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1, 505 дугаар зүйлийн 505.1-д зааснаар хэргийг шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

### 3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

#### А. Хууль хэрэглээний алдаа:

Шүүхийн шийдвэрийн хувьд ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3, 318.4, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шийдвэрлэсэн нь хууль хэрэглээний хувьд алдаатай, нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг бүрэн гүйцэд тодруулаагүй алдааг гаргажээ. Энэ нь ИХ-ийн 294 дүгээр зүйлийн 294.2.3-т заасан “хөлслүүлэгчийн санал болгосон зах зээлийн үнэд тохирсон нэмэгдэл хөлс төлөхөөс хөлслөгч татгалзсан” бол гэрээг дуусгавар болгох, түүнчлэн 299 дүгээр зүйлийн 299.1-д заасан “хөлслөгч нь хөлслөн авсан эд хөрөнгийн эзэмшлийг өмчлөгчийн болон бусад халдагаас хуульд заасан арга хэрэглэхээр хамгаалах эрхтэй” байтал өмчлөгчийн орон байрыг Н хаяж явсан нь дээрх хуулийн зохицуулалтаар гэрээ дуусгавар болсонд тооцохоор байна.

Хэдийгээр талууд түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй боловч ИХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж, нэг тал нь түрээсийн төлбөр төлж, нөгөө тал нь орон сууцыг ашиглуулж байсан тул ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1-д зааснаар түрээсийн гэрээний харилцаа үүссэн байна.

Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлага болсон эрүүл мэндэд учирсан хохирлын талаар Улаанбаатар Сонгдо, Солонгос улсад хийлгэсэн эмчийн магадлагаа, гэрчийн мэдүүлэг зэрэг баримтуудаар эрүүл мэндэд учруулсан хохирлыг тогтоох боломжгүй байхад анхан шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2-т “шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл тайлбар, түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримыг цуглуулах, өгөх” үүрэгтэй байтал нотлох баримтаа гаргаж өгөөгүй байхад хэргийг буруу шийдвэрлэсэн алдаа гарчээ.

*Ажил гүйцэтгэх гэрээнд хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- ИХ-ийн 225 дугаар зүйлийн 225.1 дэх хэсэгт заасан нэмэлт хугацаа тогтоосон эсэхийг дүгнэхдээ ИХ-ийн 225.2 дахь хэсгийн заалтыг анхаараагүй, гэрээний үүрэг зөрчснөөс талууд гэрээнээс татгалзахтай холбоотой маргаанд нэмэлт хугацаа тогтоох, урьдчилан сануулах гэсэн хуулийн зохицуулалтыг буруу хэрэглэсэн;
- Гэрээний үүрэг зөрчснөөс талууд гэрээнээс татгалзахтай холбоотой маргаанд нэмэлт хугацаа тогтоох, урьдчилан сануулах шаардлагатай гэсэн хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн;

- Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой маргаанд ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1-д заасан ажлын үр дүнг хүлээн авсан үйл баримтын талаар дүгнэлт хийгээгүй;
- Гэрээг цуцалж түүнээс үүсэх үр дагаврыг шийдсэн атлаа ИХ-ийн 343.1, 236.6-д зааснаар алданги гаргуулж шийдвэрлэсэн нь ИХ-ийн 205.1-т нийцээгүй;

**Жишээ нь: Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны 12 сарын 08-ны өдрийн 1962 дугаар шийдвэр**

*1. Хэргийн товч агуулга:*

Нэхэмжлэгч “Т.Х.Д” ХХК нь “ЦНЖ” ХХК-тай хайгуулын өрөмдлөгийн ажлын 500 тууш өрөмдлөг хийлгэхээр 2011 оны 06-р сарын 4-нд гэрээг байгуулж, ажлын хөлсөнд 60.021.000 төгрөг өгсөн. Ажил гүйцэтгэх гэрээг хугацаандаа гүйцэтгээгүй тул гэрээнд өөрчлөлт оруулахдаа ажилд гаргаагүй хоног тутамд 1 хувийн алданги төлөхөөр тохиролцжээ. “ЦНЖ” ХХК-аас ажил гүйцэтгэх гэрээг цуцалж, 25.000.000 төгрөгийг буцаан авч, үлдэгдэл төлбөрт 35.021.000 төгрөг, алдангид 41.394.480 төгрөг гаргуулахаар нэхэмжилжээ.

Талууд гэрээний алдангийн хэмжээн дээр маргажээ.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

Талуудын тохиролцсон 1 хувийн алдангийн хэмжээг хуульд нийцүүлэн 0.5 хувь багасгаж, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой гарсан зардлыг хасч, ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1, 232 дугаар зүйлийн 232.6 дахь хэсэгт зааснаар “ЦНЖ” ХХК-аас 40.922.270 төгрөгийг гаргуулан “Т.Х.Д” ХХК-д олгож, “Т.Х.Д” ХХК-ийн 35.493.210 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс:

“ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1” гэснийг “ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1” гэж, “40.922.270” гэснийг “35.626.000” гэж, “35.493.210” гэснийг “40.789.480” гэж өөрчилж, шийдвэрийг тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

*3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан шатны шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ алданги тооцох тухай хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэжээ. Талууд гэрээг цуцалсан нөхцөлд үүргийн гүйцэтгэлийг хангах тухай ойлголт байхгүй болох тул алданги гаргах үндэслэлгүйг шүүх анхаараагүй байна.

**А. Нотлох баримт үнэлэх:**

Анхан шатны шүүх зохигчдыг гэрээнээс татгалзсан гэж үзсэн атлаа тэдгээрийг “алданги төлөхөөр тохиролцсон” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагын алданги шаардсан хэсгийг хангасан нь Иргэний хуулийн 205 дугаар зүйлийн 205.1-д заасан зохицуулалттай нийцээгүй байна.

Гэрээнээс татгалзах эрх нь гэрээ буюу хуульд зааснаас үл хамааран тухайн гэрээний үүргийг харилцан буцаах харилцаа болгон өөрчлөх эрх зүйн ойлголт учраас ингэснээр талууд гэрээний үүргийг гүйцэтгүүлэхээр харилцан бие биенээсээ шаардах эрх аль ч тохиолдолд дуусгавар болох ёстой.

**Б. Утга найруулга, техникийн шинжтэй алдаа:**

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын “Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 341.1” гэснийг “Иргэний хуулийн 343.1” гэж өөрчлөхийг хяналтын шатны шүүхээс засч, анхааруулсан байна.

*Бусад гэрээний төрлүүдэд хуулийн зүйл хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- ИХ-ийн 413 дугаар зүйлийн 413.1-д заасан худалдааны зуучлагч, ИХ-ийн тээвэр зуучлалын харилцааг зохицуулсан хуулийн зүйл заалтыг баримтлалгүй хэргийг шийдвэрлэсэн;
- Гэрээний хүчин төгөлдөр байдлын талаар дүгнэлт өгөөгүй, ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан хэлцлээс үүсэх үр дагаврыг, 56.5-д зааснаар хэлцэл хийсэн талууд уг хэлцлээр шилжүүлсэн бүх зүйлээ харилцан буцааж өгөх, боломжгүй бол үнийг төлөх үүрэгтэй байтал, ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1-д зааснаар үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэж хууль хэрэглээний хувьд алдаа гаргасан;
- ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1-д зааснаар ажил гүйцэтгэх гэрээний дагуу хэлэлцэн тохиролцсон хөлсийг төлөх үүрэгтэй байтал хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн;
- ИХ-ийн 205 дугаар зүйлийн 205.1-д зааснаар гэрээнээс татгалзаж, өгсөн авсан зүйлээ буцааж авах агуулгатай байхад эд хөрөнгө доголдолтой байсны улмаас гэрээг цуцалж хохирол шаардан 256 дугаар зүйлийн 256.1 дэх хэсгийг баримтлан хэргийг шийдвэрлэсэн;
- Хамтран ажиллах гэрээнээс олсон ашиг гаргуулах тухай нэхэмжлэлийг шийдвэрлэхэд ИХ-ийн 480 дугаар зүйлийн 480.1.1-д заасан хугацаа дууссан эсэхийг тодорхойлоогүй;

- Хамтран ажиллах гэрээний үүрэгтэй холбоотой маргаанд ИХ-ийн 478 дугаар зүйлийн 478.8, 478.11-т заасан талуудын ашиг хуваах, алдагдал хариуцах ИХ-ийн 477 дугаар зүйлийн 477.4-т заасан хамтран өмчлөх хөрөнгөтэй холбоотой эсэх зохицуулалтыг анхаарч дүгнэлт өгөөгүй;

Гэрээний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдэд хууль хэрэглээний хувьд алдаатай, буруу тайлбарласан байна. Тухайлбал, ИХ-ийн 204 дүгээр зүйлийн “гэрээнээс татгазах журам”, 205 дугаар зүйлийн “гэрээний аль нэг тал гэрээнээс татгалзсанаас үүсэх үр дагавар”, 221 дүгээр зүйлийн “хүндэтгэн үзэх үндэслэлээр талууд гэрээнээс татгалзах”, 225 дугаар зүйлийн “үүрэг зөрчсөнөөс талууд гэрээнээс татгалзах”, 227 дугаар зүйлийн “үүрэг зөрчсөнөөс үүсэх хариуцлага” гэсэн гэрээнээс татгалзах, үүсэх үр дагаврын талаарх хуулийн зохицуулалтуудыг буруу тайлбарлан хэрэглэжээ.

Түүнчлэн ИХ-ийн 189 дүгээр зүйлд заасан “гэрээний талуудын чөлөөт байдал”, 198 дугаар зүйлийн “гэрээг тайлбарлах” журмын дагуу гэрээний агуулгыг зөв тодорхойлж чадаагүй, хөөн хэлэлцэх хугацааг буруу тооцсон, талуудын хооронд байгуулагдсан гэрээний харилцааг буруу тодорхойлж, талуудын хооронд байгуулсан гэрээний тохиролцоо хуульд нийцсэн эсэх, байгууллагын дүрэм нь хуульд нийцсэн эсэх талаар дүгнэж чадаагүй зэрэг гэрээтэй холбоотой нийтлэг зөрчлүүд илэрчээ.

Гэрээний эрх зүйн хэрэг, маргаан нь төлбөр, хүү, алданги гаргуулах асуудалтай холбогддог тул үнийн дүнг үнэн зөв тооцох асуудалд анхааралтай хандах ёстой. Судалгаанаас үзэхэд тооцооллын алдаа нэлээдгүй гарсан байх бөгөөд энэ төрлийн алдааг анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн хэрэгт аль алинд нь гаргажээ.

Мөн гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ хуульд нийцсэн дүгнэлт хийгээгүй, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоогоогүй, зохигчдын хооронд үүссэн маргааны талаар эрх зүйн дүгнэлт өгөөгүй, нэхэмжлэлийн шаардлагад зааснаас өөр асуудлыг шийдвэрлэсэн зэрэг зөрчлүүд илэрчээ.

### **3.2. Өмчлөх эрх, хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцох хэрэг, маргаан**

Иргэнлэг эрх зүйн системд өмчлөл гэсэн ойлголтыг “өмчлөх эрх” гэсэн хүрээнд, харин эзэмшил нь тухайн өмчлөх эрхийг ил тод байдлаар хэрэгжүүлж буй бодит байдал гэж авч үздэг, өөрөөр хэлбэл, эзэмшил бол эрх биш гэж үздэг.<sup>12</sup> Өмчлөгч нь өөрийн хөрөнгөө захиран зарцуулах, аливаа бусад этгээдээс хамгаалах эрхтэй. Иймд иргэний эрх зүйн маргааны төрөлд өмчлөгч болохоо тогтоолгох, бусад этгээдийн зүгээс ашиглах эрхийг хязгаарлах зорилгоор илүүтэй шүүхэд хандаж байна.

*Өмчлөх эрх болон хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцох маргаанд хуулийн зүйл хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- Гэрээнээс татгалзах, цуцалсны улмаас эд хөрөнгөө буцаан шаардах зэрэг үр дагаврыг шийдвэрлэх тохиолдолд үүргийн ерөнхий зохицуулалт болох ИХ-ийн 227 дугаар зүйлийн 227.3, 205 дугаар зүйлийн 205.1 дэх заалтаас гадна гэрээний тусгай зохицуулалтыг анхаараагүй; Тухайлбал, ИХ-ийн 249 дүгээр зүйлийн 249.1, 256 дугаар зүйлийн 256.1, 476 дугаар зүйлийн 476.1, 477 дугаар зүйл, 478 дугаар зүйлийн 478.3;
- Газар эзэмших эрх нь хүчингүй болсон тохиолдолд газрын өмчлөгч, түүний дээрх объектын өмчлөгч нарын хоорондын маргааныг шийдвэрлэхэд ИХ-ийн 85 дугаар зүйлийн 85.2-д заасан газрын үндсэн бүрдэл хэсэг гэсэн ойлголтыг буруу тайлбарлаж, 119 дүгээр зүйлийн 119.1 дэх, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсгийг хэрэглэхэд алдаа гаргасан;
- ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийн “хууль бус эзэмшил” гэсэн агуулгыг гаргахтай холбоотой дүгнэлтийг хийхэд ИХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.1, 92 дугаар зүйл, 93 дугаар зүйл, 100 дугаар зүйлийн 100.1, 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсэгт заасан асуудлын хүрээнд дүгнэлт өгөөгүй, эсхүл эдгээр заалтыг шаардах эрхийг үндэслэл болгосон;
- ИХ-ийн хууль ёсны өмчлөгчийн шаардах эрхийг тодорхойлсон ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийг хэрэглэхдээ хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг тодорхойлсон тус хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнөөс үүсэх үүргийн 492 дугаар зүйлийн 492.1.1 дэх заалтыг давхар баримталсан;
- Эд хөрөнгө түрээслэх, хөлслөх гэрээний үүрэг дуусгавар болж, үр дагаварт эд хөрөнгөө шаардсан байхад гэрээний үүргийн холбогдох зохицуулалтыг баримтлаагүй ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийг баримталсан;
- ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.2 дахь хэсгийг баримтлан шийдвэр гаргахдаа хөршийн эрхийн зохицуулалт болох 135 дугаар зүйлийн 135.2 дахь заалттай давхардуулж авч үзсэн;

<sup>12</sup> Дам ишлэв. Ж.Оюунтунгалаг. Харьцуулсан иргэний эрх зүй.УБ.,59-р хуудас



- Сууц өмчлөгчдийн дундын эд хөрөнгийг тодорхойлохтой холбогдох хуулийн зохицуулалтыг зөв тайлбарлан, хэрэглэж чадаагүй. Тухайлбал, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгө, дэвсгэр болон орчны газар, Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан нэгдмэл бус барилгыг хэсэгчлэн ашиглалтад оруулах тухай хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн;
- ИХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт “эзэмшил үүсэх”, 105 дугаар зүйлийн 105.1 дэх хэсэгт “эд хөрөнгө өмчлөх эрхийг олж авах давуу эрх”, 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсэгт заасан “өмчлөгчийн шаардах эрх” гэсэн зохицуулалтуудыг уялдуулан тайлбарлаж хэрэглэхгүй;
- Хамтран ажиллах гэрээний дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө үүссэн эсэх асуудалд ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсэгт зааснаар өмчлөгч гэж тогтоосон байхад давж заалдах шатны шүүхээс ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.1-д заасан дундын өмч, 476 дугаар зүйлийн 476.1-д заасан хамтран ажиллах гэрээний зохицуулалтаар хэргийг шийдвэрлэж хууль хэрэглээний алдаа гаргасан;

**Жишээ нь: Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2110 дугаар шийдвэр**

*1. Хэргийн товч агуулга:*

Баянгол дүүргийн 4-р хороонд байрлах үйлчилгээний зориулалттай 4 дүгээр давхрын 200 м.кв талбайг 2010 оны 12 сараас 1 жилийн хугацаатай ашиглахаар түрээсийн гэрээ байгуулжээ. Хариуцагч Б нь төлбөрөө хугацаандаа төлөхгүй, өөрөө олдохгүй алга болоод байдаг тул түрээсийн төлбөрт 7.800.000 төгрөг гаргуулж, байраа чөлөөлүүлэхээр маргажээ.

Хариуцагчийн зүгээс зохигчдын хооронд байгуулагдсан “Ажлын байр түрээслэх гэрээ”-г хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар сөрөг нэхэмжлэл гаргажээ.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1, 318 дугаар зүйлийн 318.4-т зааснаар нэхэмжлэгч Э, хариуцагч Б нарын хооронд байгуулсан түрээсийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцож, ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.2-д зааснаар Баянгол дүүргийн 4-р хороонд байрлах 200м.кв байрыг Б-ийн эзэмшлээс чөлөөлж, ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасныг баримтлан хариуцагч Б-ээс 1.000.000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Э-д олгож, хариуцагчаас 5.000.000 төгрөгийн



шаардлагыг биелүүлснийг дурьдан, 1.800.000 төгрөгийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн “... Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.2...” гэснийг “Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5...” гэж өөрчлөлт оруулжээ.

Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

*3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

*А. Хууль хэрэглээний алдаа:*

Анхан шатны шүүх түрээсийн гэрээг ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.4-т заасныг зөрчсөн, хуулийн хүчин төгөлдөр бус гэрээ гэж зөв дүгнэсэн боловч ИХ-ийн 106 дугаар зүйлийг хэрэглэж хууль хэрэглээний алдаа гаргасан байна.

***Жишээ нь: Баянзүрх дүүргийн шүүхийн 2012 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 2278 дугаар шийдвэр***

*1. Хэргийн товч агуулга:*

Нэхэмжлэгч Э-ийн газар дээр хууль бусаар амьдарч байгаа Ө-с өмчлөгч өөрийн газрыг чөлөөлүүлэхээр маргажээ. Ө-ийн хувьд тухайн газар дээр 10-аад жил амьдарч байгаа бөгөөд газрын албанд тухай газрыг өмчилж авах талаар хөөцөлдөж байгаа, нэхэмжлэгч Э нь удаан хугацаанд уг газар дээр амьдарч байгаагүй тул нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй гэж талууд маргажээ.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.2, 106.4, 183 дугаар зүйлийн 183.1 дэх заалтыг баримтлан Ө-ийн хууль бус эзэмшлээс газар чөлөөлүүлэхээр шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн “...ИХ-ийн 106.2, 106.4...” гэснийг хасч, “ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1...” гэж өөрчилж, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээсэн байна.

Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

**3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:**

Анхан шатны шүүх иргэний хуулийн нэхэмжлэгчийн шаардах эрхийн холбогдох зохицуулалтыг буруу хэрэглэж, хууль ёсны эзэмшигчид хамааралтай заалт хэрэглэсэн байна.

**А. Хууль хэрэглээний алдаа:**

Анхан шатны шүүх хариуцагчийн хууль бус эзэмшлээс маргааны зүйл болох газрыг чөлөөлж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн атлаа өмчлөлийн зүйлийн эзэмшилтэй холбоогүй шаардлага гаргах өмчлөгчийн эрхийг тодорхойлсон ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.2-т заасан зохицуулалтыг шийдвэрийн үндэслэл болгосон нь хуулийн хэрэглэвэл зохих зүйл, заалтыг хэрэглээгүй алдаа гаргажээ.

**Жишээ нь: Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны 09 дүгээр сарын 2-ны өдрийн 1365 дугаар шийдвэр**

**1. Хэргийн товч агуулга:**

Нэхэмжлэгч Ц-н Сүхбаатар дүүргийн 16-р хорооны 700м.кв газар дээр хариуцагч М хууль бусаар амьдарч байгаа тул өөрийн өмчлөлийн газрыг чөлөөлүүлэхээр маргажээ.

**2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:**

**Анхан шатны шүүхээс:**

Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч Ц-н өмчлөлийн газраас М-н эд хөрөнгийг албадан нүүлгэхээр шийдвэрлэжээ.

**Давж заалдах шатны шүүхээс:**

Сүхбаатар дүүргийн шүүхийн шийдвэрийн 1 дэх заалтыг “Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1-д зааснаар Ц-ийн өмчлөлийн газрыг чөлөөлж, газрыг нэхэмжлэгчид хүлээлгэн өгөхийг хариуцагч М-д үүрэг болгосугай” гэж өөрчилж, бусад хэсгийг хэвээр үлдээжээ.

**Хяналтын шатны шүүхээс:**

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

**3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:**

Шүүх нэхэмжлэгчийн өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ хариуцагч М-д холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагад хамааралгүй хуулийн заалтыг хэрэглэсэн байна.

А. Хууль хэрэглээний алдаа:

Нэхэмжлэгч Ц нь өмчлөх эрхийн гэрчилгээтэй өөрийн өмчлөлийн газрыг М-с чөлөөлүүлэхээр хандсан байхад Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсгийн заалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн байна.

Өмчлөх эрхийн маргааныг хянан шийдвэрлэхэд ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсэгт заасан “хууль бус эзэмшигч” мөн эсэхийг тогтоохтой холбоотой дүгнэлтийг хийхэд ИХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.1, 92 дугаар зүйл, 100 дугаар зүйлийн 100.1, 102 дугаар зүйлийн 102.2-т заасан талаар дүгнэлт өгөөгүй, эсхүл эдгээр заалтын шаардах эрхийн үндэслэл болгон шийдвэрлэсэн нь алдаатай байна.

Түүнчлэн өмчлөх эрхийн маргаанд Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн зохицуулалтыг нэг мөр хэрэглэх, тайлбарлах, газар эзэмших эрх нь хүчингүй болсон тохиолдолд газар, түүний дээрх объектын өмчлөгч нарын хоорондын маргааныг шийдвэрлэхэд ИХ-ийн 85 дугаар зүйлийн 85.2, 119 дүгээр зүйлийн 119.1, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсгийг буруу хэрэглэжээ.

Өмчлөгчийн шаардах эрх, хүчин төгөлдөр бус хэлцлээс үүсэх үр дагавар зэрэгтэй холбоотой хуулийн зохицуулалтыг зөв тайлбарлан хэрэглэх, нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодорхойлох, шаардах эрхийн үндэслэлийг гаргахад түгээмэл алдаа, зөрчлүүд байна.

### 3.3. Хөдөлмөрийн маргаан

Хөдөлмөрийн эрх зүйн маргаан анхан шатны шүүхээс 2012 онд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 2.6 хувь, 2013 онд 3.03 хувийг тус тус эзэлсэн<sup>13</sup> байна.

Ажлаас буруу халагдсантай холбоотой хөдөлмөрийн маргаанд ажилтны ажлаас халсан тушаалын эрх зүйн үндэслэл болох хуулийн зохицуулалт, ажилтны гаргасан сахилгын зөрчилд тохирсон байх ёстой. Хөдөлмөрийн эрх зүйн маргааны төрөлд ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой нэхэмжлэл дийлэнх хувийг эзэлж байх тул хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажилтныг ажлаас халсан, сахилгын шийтгэл ногдуулсан тушаалын бодит байдлын болон эрх зүйн үндэслэлд шүүгч нарын зүгээс тодорхой дүгнэлт өгөх шаардлагатай.

Түүнчлэн хөдөлмөрийн гэрээ нь иргэний эрх зүйн зарим төрлийн төстэй гэрээнүүд болох хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээний төрлөөс ялгаатай авч үзэх хэрэгтэй юм.

*Хөдөлмөрийн маргаанд хуулийн зүйл хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5 дахь хэсэгт заасан мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсноор ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах ёстой атал буруутай үйлдэл гаргасан эсэхийг зөв тогтоогоогүй;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заасан “байнгын ажлын байр”-ны ойлголтыг авч үзэхдээ хөдөлмөрийн харилцаа зөвхөн байнгын ажлын байранд хамаарна гэж хуулийг буруу тайлбарласан;
- Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2, 128.1.9 дэх хэсэгт заасан маргаанд ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 227 дугаар зүйлийн 227.3 дахь хэсгийг баримталсан;
- Сахилгын шийтгэл ногдуулах, хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4-т заасан “хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан” үндэслэлээр ажлаас халагдсантай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ 131 дүгээр зүйлийн 131.2-т заасан сахилгын шийтгэл ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа, 131.3 сахилгын шийтгэл давхардуулан ногдуулахгүй байх, 131.4 сахилгын шийтгэлд тооцох хугацаа зэргийг анхаараагүй, хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Дээрх хуулийн 129 дүгээр зүйлийн 129.2-т заасан ажилтны ажлаас буруу халагдсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай гомдлоо ажил олгогчийн

<sup>13</sup> “Монгол улсын шүүхийн тайлан” 2013, УБ., 95-хуудас

шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор шүүхэд гаргах эрхтэй гэсэн зохицуулалтыг үндэслэл муутай тайлбарласан. Мөн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан ажил олгогчийн үүргийг зөв тодорхойлоогүй;

- Дээрх хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан үндэслэл нь 36.2-т заасан адил чанарын ажил, албан тушаалд ажиллуулах нөхцлүүдийг буруу тодорхойлсон;
- Тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д заасан байнгын ажлын байранд байгуулсан хөдөлмөрийн гэрээний хугацааг 32 дугаар зүйлийн 32.1-д заасан өөр ажилд түр шилжүүлэх үеийн зохицуулалттай холбож тайлбарлаж чадаагүй;
- Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д зааснаар цалин хөлсийг олгоогүйтэй холбоотой маргаанд 141 дүгээр зүйлийн 141.3-д заасан алданги тооцох зохицуулалтыг хэрэглээгүй;
- Дээрх хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д зааснаар ял шийтгүүлсэн тогтоол хүчин төгөлдөр болсонтой холбоотойгоор хөдөлмөрийн гэрээг цуцлах зохицуулалтыг Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчид хамаарах буюу төрийн үйлчилгээний албан хаагчид хамаарахгүй байх зохицуулалттай холбож тайлбарлаагүй;
- Дээрх хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд шилжүүлж ажиллуулсан тухай маргааныг шийдвэрлэхдээ тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаар хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүйд ажилтан буруугүй болохыг анхаараагүй;
- Дээрх хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсгийг баримтлах байтал давхар ИХ-ийн 495 дугаар зүйлийн 495.1 дэх хэсгийг баримталсан нь буруу;
- ИХ-ийн 366 дугаар зүйлийн 366.1-д заасны дагуу хөлсөөр ажиллах гэрээг тодорхой бус хугацаагаар сунгагдсанд тооцох хуулийн зохицуулалтыг хэрэглээгүй;

**Жишээ нь: Сүхбаатар дүүргийн шүүхийн 2013 оны 04 сарын 19-ний өдрийн 877 дугаар шийдвэр**

**1. Хэргийн товч агуулга:**

Нэхэмжлэгч Б нь “Ө.С” ХХК-д редактороор ажиллаж байгаад 2013 оны 01 сарын 21-ний өдрийн 13/07 тоот тушаалаар ажлаас үндэслэлгүй халагджээ. 2013 оны 02 сарын 01-ны өдрөөс орон тоо цомхотгож байгаа гээд “3 сарын тэнцэх цалинтай тэнцэх мөнгө аваад ажлаасаа гарах уу, улс төрийн албанд ажиллах санал тавихаар нь “тэтгэмжээ аваад ажлаасаа гаръя” гэхэд эрхлэгч нь “чөлөөлөгдөх өргөдлөө өг” гэснээр өргөдлөө өгтөл Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д заасныг баримтлалгүй 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан ажилтан өөрөө хүссэн гэсэн үндэслэлээр ажлаас чөлөөлж, тэтгэмж олгоогүй байна. Иймээс 2013 оны 01 сарын 21-ний өдөр хүртэлх цалин 900,000 төгрөг, өмгөөлөгчийн

хөлс 300,000 төгрөгийг гаргуулж, ажилд эгүүлэн тогтоолгохоор нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хариуцагчийн зүгээс нэхэмжлэгч Б нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, 2012 оны 12 сарын 18, 2013 оны 01 сарын 11, 2013 оны 01 сарын 15-ны өдрүүдэд хийгдсэн редакцийн албадын хурлаас өөр албанд шилжүүлэх санал тавихад хүлээн зөвшөөрөөгүй нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байна гэж ойлгосон ба энэ талаар хурлын тэмдэглэлд тусгагдсан болно. Нэхэмжлэгч Б-г ажлаас чөлөөлөгдөх хүсэлт, өргөдлөө өгч гаргах үед орон тоо бүтэц өөрчлөгдөөгүй, ажил үүргээ гүйцэтгээд явах бүрэн боломжтой байсан. Өөрийн хүсэлтээр гарсан тул ажил олгогч ажилтанд ажлаас халагдсаны тэтгэмжийг өгөх хуулийн зохицуулалт байхгүй гэж талууд маргажээ.

## *2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

### Анхан шатны шүүхээс:

Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан ажлаас буруу халсан үндэслэл тогтоогоогүй тул “Ө.С” ХХК-ны редакторын ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин олговорт 900,000 төгрөг, эрх зүйн туслалцаа өмгөөлөгчөөс авсны зардалд 300,000 төгрөг тус тус гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

### Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Б-г ажилд эгүүлэн тогтоож, “Ө.С” ХХК-аас 1.499.992 төгрөгийг гаргуулж, өмгөөллийн зардалд 300,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гээд шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээсэн байна.

### Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

## *3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан шатны шүүхээс өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн гэж дүгнэсэн нь хуульд нийцээгүй, хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт цугларсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд эрх зүйн дүгнэлт өгч чадаагүйн зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байна.

### *А. Нотлох баримт үнэлэх:*

Нэхэмжлэгч Б нь “Ө.С” ХХК-ны ерөнхий эрхлэгчид хандаж гаргасан “2013 оны 02 сарын 01-ний өдрийн орон тооны цомхотгол хийхтэй холбогдуулж намайг улс төрийн албанд сэтгүүлчээр ажиллах санал тавьсан, миний бие сэтгүүлчээр ажиллах бодолгүй байгаа тул ажлаас чөлөөлж өгнө үү” гэсэн өргөдөл хүсэлт нь “Улс төрийн албанд сэтгүүлчээр ажиллуулах тухай”, “Ө.С” ХХК-ний ерөнхий эрхлэгчийн саналд тайлбар өгснийг үүрэгт ажлаас өөрийн санаачилгаараа халагдсан гэж үзэх боломжгүй, энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасантай нийцэхгүйг анхан шатны шүүхээс авч үзээгүй байна.

Ажилтны эрхэлж буй ажил, албан тушаалын орон тоо хасагдсан бол ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д зааснаар хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачлагаар цуцлах ёстой бөгөөд энэ үндэслэл нь мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5, 42 дугаар зүйлийн 42.1-д заасан үүргийг үүсгэдэг тул ажил олгогчийн хуульд нийцээгүй дээрх тушаал нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөнөөс гадна ажилтныг ажлаас үндэслэлгүй халсан гэж үзэх нөхцөл болсныг анхаараагүй алдаа гаргажээ.

Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ бие даасан нэхэмжлэлийн шаардлагыг түүний үндэслэл аль нь болохыг тодорхойлсон холбогдох хуулийн зохицуулалтыг баримтлах ёстой. Тухайлбал, ажлаас халсан, сахилгын шийтгэл ногдуулсан тушаал хүчингүй болгуулах, эрүүл мэнд нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгэх зэрэг шаардлагууд нь бие даасан нэхэмжлэлийн шаардлага мөн эсэхийг тодорхой болгох.

Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл тус бүрийн онцлог, түүнтэй холбоотой заавал шалгах нөхцлүүдийг Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэн тодруулах, хэрэглэх асуудалд анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, ИХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2, 40.1.3, 40.1.4, 40.1.5 дугаар зүйлүүд, 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.3, 37.1.4, 39 дүгээр зүйлийн 39.1, 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан нөхцлүүд мөн эсэхийг тогтоох.

Мөн хөдөлмөрийн эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл нь хууль, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд үндэслэсэн эсэхийг шалгах, хөөн хэлэлцэх хугацаа, шүүхэд энэ талаар гомдол гаргах хугацаа зэргийг анхааралгүй хэргийг шийдвэрлэсэн зөрчлүүд байна.

Цаашид хөдөлмөрийн маргаанд нарийвчилсан хуулийн зохицуулалтыг хэрэглэхэд анхаарах хэрэгтэй байна. Тухайлбал, Дипломат харилцааны тухай Венийн конвенц, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль зэргийн авч үзэх хэрэгтэй байна.



### 3.4. Гэр бүлийн маргаан

Гэр бүлийн эрх зүйн маргааныг анхан шатны шүүхээс 2012 онд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 14 хувь, 2013 онд 12.1 хувийг тус тус эзэлсэн<sup>14</sup> нь өмнөх оноос 1.9 хувиар буурсан байна. Харин 2012-2013 онд гэр бүлийн маргааны шийдвэрлэгдсэн нийт хэргийн 91.1 хувийг гэрлэлт цуцлах маргаан эзэлж байна. Эндээс гэр бүлийн эрх зүйн маргаан, тэр дундаа гэрлэлт цуцлалттай холбоотой шийдвэрлэсэн хэргийг судлах шаардлага, ач холбогдол өсч байна. Иймээс нийт шийдвэрлэсэн хэргийн дотор гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаантай хэргийн эзэлж байгаа хувь хэмжээ их байгаагийн зэрэгцээ энэ төрлийн хэргийг шийдвэрлэхэд хяналтын шатны шүүхээс өөрчлөгдөж, хүчингүй болсон шийдвэрт анхаарлаа хандуулах шаардлагатай байна.<sup>15</sup>

*Гэр бүлийн маргаанд хуулийн зүйл хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- Гэр бүлийн тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар эцэг, эх эрхээ хамгаалуулах байхад шүүх мөн хуулийн 14, 21 дүгээр зүйлийг буруу тайлбарлаж хэрэглэсэн;
- Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т зааснаар гэрлэлтийг эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр шууд цуцлах зохицуулалтыг хянаж үзэлгүй хэргийг шийдвэрлэсэн;
- Хүүхдийн эрхийг хамгаалах конвенц, ИХ-ийн 9 дүгээр 9.4.3 дахь заалт, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.2 дахь заалтуудыг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн талаарх ИХ-ийн 126, 127 дугаар зүйлд заасан зохицуулалт, түүнчлэн гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваахдаа мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.1, 129 дүгээр зүйлийн 129.2, 129.4-г тус тус буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Гэрлэлтээ цуцлуулж тусдаа амьдарч байгаа эцэг, эхтэй нь хүүхдийг уулзуулахдаа Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4-т зааснаар гэрлэгчид харилцан тохиролцох боломжтой байхад хуулийг буруу тайлбарласан;
- Үрчлэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжгүй маргаантай байхад онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж, ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.4, 145 дугаар зүйлийг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйл, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасныг буруу тайлбарлаж

<sup>14</sup> “Монгол улсын шүүхийн тайлан” 2013, УБ., 95-р хуудас

<sup>15</sup> Гэр бүлийн маргаантай хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаарх тойм.2013



хүүхдэд нэмэлт зардал зайлшгүй шаардагдах нөхцөл байдлыг тодруулалгүй хэргийг шийдвэрлэсэн;

- Гэр бүлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасныг буруу тайлбарлан хэрэглэж, урьд нь хүүхдийн тэтгэлэг тогтоогоогүй, хариуцагч хүүхдийн тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийгээгүй, нэхэмжлэгч энэ талаар анх удаа нэхэмжлэл гаргаж байхад тэтгэлэгийг нөхөн гаргуулсан;
- ИХ-ийн 85.1-д заасан устгах буюу зориулалтыг нь алдагдуулахгүйгээр салгаж үл болох эд юмсын бүрдэл хэсгийг салгаж шийдвэрлэсэн;

**Жишээ нь: Баянзүрх дүүргийн шүүхийн 2011 оны 12 сарын 08-ны өдрийн 1962 дугаар шийдвэр**

*1. Хэргийн товч агуулга:*

Нэхэмжлэгч У нь С-тэй 1998 онд гэрлэлтээ батлуулсан бөгөөд 1998 оны 11 сард охин Н, 2001 онд охин Х, 2004 онд хүү Г, 2007 онд хүү Ц нар төржээ. Мөнгө, хардалтын улмаас байнга хэрүүл гарч хамт амьдрах боломжгүй болсон тул гэрлэлт цуцлуулж, хүүхдийн тэтгэлэг тогтоолгож, 4 хүүхдээ эх У-ийн асрамжинд авч, байшингийн өмчлөгчөөр тогтоолгож, гэр бүлийн гишүүний дундын эд хөрөнгөөс гаргуулахаар шүүхэд ханджээ.

Хариуцагчийн зүгээс хүү Ц-ийн төрсөн эцэг мөн эсэхийг тогтоолгохоор сөрөг нэхэмжлэл гаргаж маргасан байна.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

Баянзүрх дүүргийн шүүхээс Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар С болон У нарын гэрлэлтийг цуцалж, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэгт зааснаар хүүхдүүдийг эхийн асрамжид үлдээн тэтгэлэг тогтоож, хүү Ц-ийн эцэг нь С биш болохыг тогтоож, Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.1, 126.3, 129 дүгээр зүйлийн 129.2 дахь хэсэгт зааснаар Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд байрлах 2 өрөө орон сууцыг хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болохыг тогтоож, уг орон сууцыг У, Н, Х, Г, Ц нарын өмчлөлд үлдээж, У-с 5.359.833 төгрөгийг гаргуулж С-д олгохоор шийдвэрлэсэн байна. Харин орон сууцыг бусдад түрээслэсний улмаас олсон орлогыг гаргуулах тухай нэхэмжлэлгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт “...нэхэмжлэгч У-с 75.000 төгрөгийг, хариуцагч С-с 75.000 төгрөгийг тус тус гаргуулж, “Бест эстимент” ХХК-д олгосугай” гэснийг “...хариуцагч С-с 75.000 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч У-д олгосугай” гэж өөрчилж шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

*3. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2 дахь заалтын шаардлагыг бүрэн хангаагүй байна.

**А. Хууль хэрэглээний алдаа:**

Шүүх У болон С нарын гэр бүлийн дундын өмчлөлийн хөрөнгийг хувиарлахдаа тэдгээрийн хуваарьт өмч, гэр бүлийн гишүүний дундын хөрөнгийг нарийвчлан тодорхойлоогүй.

Мөн гэрлэгчдийн насанд хүрээгүй хүүхэд одоо хэний асрамжинд байгаа хийгээд тэдгээрийн эрүүл мэнд, сурч хүмүүжих бололцоо, эцэг, эхийн хэний асрамжид байвал хүүхдүүдийн эрх ашигт нийцтэй болохыг шүүх сайтар хянан үзээгүй байна.

Гэрлэгчдийн хүүхдүүд болох Г, Х, Н нараас шүүх асрамжийн талаар санал авсан нь хэлбэрийн хувьд хуулийн шаардлагыг хангасан мэт боловч уг асуудлыг нарийвчлан тодруулсны үндсэн дээр хэргийг шийдвэрлэх нь зүйтэй байжээ.

Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг тогтоох, энэ тухай ойлголтыг нэр мөр болгох шаардлагатай байна. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийг хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд тооцон шийдвэрлэсэн алдаа, зөрчлүүд байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэлийг шийдвэрлэхэд тэтгэлэгийн хэмжээг буруу тооцох зөрчил нийтлэг илэрч байна.

Түүнчлэн хүүхдийн асрамжлагчийг тогтоохдоо хүүхдийн эрх ашигт нийцэхгүй, бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэрийг гаргасан, Гэр бүлийн тухай хуулийг буруу тайлбарлан хэрэглэх зөрчлүүд түгээмэл гарчээ.

### **3.5. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих**

*Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд уг зүйлийг олж авсан этгээдээс хөрөнгөө буцаан шаардах эрхтэй гэсэн зохицуулалтыг 495 дугаар зүйлийн 495.1 дэх хэсэгтэй давхар баримталсан;
- ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх гэрээний харилцаанаас үүссэн маргаанд ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзэж хуулийг буруу хэрэглэсэн;

**Жишээ нь: Баянзүрх дүүргийн шүүхийн 2012 оны 02 дугаар сарын 9-ний өдрийн 356 дугаар шийдвэр**

#### *1. Хэргийн товч агуулга:*

Нэхэмжлэгч “Г.Ч” компани 2011 оны 01 сарын 01-нээс 03 сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд хянан баталгаажуулсан ажлын дагуу гэрэлтүүлгийн ашиглалт үйлчилгээ, урсгал засврын ажил хийж гүйцэтгэсэн. Ажлаа хийж дуусгаад хоёр талын комиссын гишүүдэд “Ажил хүлээлцэх акт” үйлдэн, хийсэн ажлаа хүлээлгэн өгсөн. Иймд Баянзүрх дүүргийн Тамгын газраас ажлын хөлс болох 23.038.843 төгрөгийг гаргуулахаар удаа дараа хандсан боловч төлбөрийг төлөхгүй байгаа тул шүүхэд хандажээ.

Харин хариуцагч талаас “Г.Ч” ХХК-тай байгуулсан гэрээ байхгүй тул гүйцэтгэсэн ажлын хөлсөө Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас гаргуулах нь зүйтэй гэж үзэж талууд маргажээ.

#### *2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

##### Анхан шатны шүүхээс:

ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д зааснаар хариуцагч Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн 23.038.843 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

##### Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн “ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1 дэх хэсэг” гэснийг “ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэг” гэж өөрчилж, бусад хэсгийг хэвээр үлдээжээ.

##### Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

*3. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Зохигчид гүйцэтгэсэн ажлын хөлсийг хариуцан төлөх эсэх асуудлаар маргасан бөгөөд шүүх хэргийн үйл баримтыг зөв тодорхойлж, нотлох баримтыг хуулийн дагуу үнэлсэн боловч, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй зөрчил гарсан байна.

*A. Хууль хэрэглээний алдаа*

Хэргийн материалд авагдсан “нийтийн эзэмшлийн гудамж талбай, орон сууц, гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн ашиглалт, үйлчилгээний урсгал засварын зардлыг 2001 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгохыг дүүргүүдийн Засаг дарга нарт ... үүрэг болгосон” Нийслэлийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 208 дугаар захирамж, Захирагчийн ажлын албаны 2011 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 1/432 тоот, 2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/36 тоот зэрэг баримт бичгээр зохигчдын хооронд гэрээ байгуулагдаагүй боловч, хариуцагчийн нутаг дэвсгэрт урсгал засварын ажлыг дангаар хийж гүйцэтгэсэн, хөлс төлөх болон цаашид гэрээний тал болохыг тухайн дүүргийн Засаг даргын газарт хариуцуулж, Нийслэлийн Захирагчийн алба шийдвэр гаргаж, гүйцэтгэсэн ажлын үр дүн нь хариуцагчийн эрх үүрэгт хамааралтай болсон байна.

Иймд ИХ-ийн 343 дугаар зүйлийн 343.1-д заасан заалтад нийцсэн байх тул анхан шатны шүүхээс хэрэглэвэл зохих хуулийн заалтыг хэрэглээгүй зөрчил гаргажээ.

***Жишээ нь: Баянзүрх дүүргийн шүүхийн 2011 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 1859 дугаар шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 870 дугаар магадлал***

*1. Хэргийн товч агуулга:*

Нэхэмжлэгч “М.П.К”-д Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсээс хяналт шалгалт хийсэн бөгөөд Татварын ногдуулалт, төлөлтийг шалгажээ. Энэ шалгалтаар “Х.Ц” ХХК-д бичилт хийж өгсөн 005889774 тоот дугаартай НӨАТ-ийн падааны борлуулалтыг тайлагнаагүй тухай дурдаж, 53.717.900 төгрөгийн татварыг нөхөн төлүүлэхээр болжээ. “Х.Ц” ХХК нь тухайн НӨАТ-ын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн гэж нэхэмжлэгчийн зүгээс үзэж, татварын нөхөн төлөх төлбөрийг нэхэмжилсэн байхад хариуцагч “Х.Ц” ХХК нь энэхүү шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргажээ.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д зааснаар хариуцагч “Х.Ц” ХХК-иас 37.602.530 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэж, нэхэмжлэлийн шаардлагаас 16.115.370 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрт заасан ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1-д заасан үндэслэл тогтоогдохгүй байх тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна.

Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.

*3. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлага болон үндэслэлийн агуулгыг эрх зүйн үүднээс зөв дүгнэж чадаагүйн зэрэгцээ хэрэгт авагдсан нотлох баримтыг ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлд заасан журмын дагуу үнэлээгүй байна.

*А. Хууль хэрэглээний алдаа*

Анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1-д заасан зохицуулалтыг дангаар хэрэглэсэн нь учир дутагдалтай болжээ. Нэхэмжлэгч татварын улсын байцаагчийн актад зааснаар хариуцагчаас аж ахуйн нэгжийн орлогын болон нэмэгдсэн өртгийн нөхөн татварт 38.181.820 төгрөг, хүүд 57.200 төгрөг, алдангид 206.100 төгрөг, торгуульд 15.272.800 төгрөг, нийт 53.717.900 төгрөг гаргуулахыг нэхэмжилсэн ба эдгээрээс хүү, торгууль, алдангийн талаарх шаардлага нь үндэслэлгүй хөрөнгөжсөнөөс учирсан хохирлыг арилгуулах агуулгатай байх тул энэ шаардлагын үндэслэлийг ИХ-ийн 495 дугаар зүйлийн 495.1-д заасан зохицуулалтаар шийдвэрлэх нь зүйтэй юм.

Хариуцагч “Х.Ц” ХХК НӨАТ-ын тайландаа хасалт хийлгэснээр үндэслэлгүй хөрөнгөжсөн бол ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1-д заасан шаардлагыг татварын улсын байцаагч гаргах ёстой боловч татварын улсын байцаагчийн актаар нөхөн татварыг нэхэмжлэгч төлөх болсон тул түүнд уг шаардах эрх шилжсэн гэж үзнэ.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэсэн ойлголтонд 3 төрлийн үндэслэл байх бөгөөд ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1, 495, 496 дугаар зүйлийн зохицуулалтуудыг ялгавартай авч үзээгүй алдаа түгээмэл байна. Үүнд:

Бусдын эд хөрөнгийг үндэслэлгүйгээр авсантай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ ИХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1, 225 дугаар зүйлийн 225.1, 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан үндэслэлтэй ялгаж авч үзэх;

Бусдын эд хөрөнгийг устгасан, хольсон, захиран зарцуулснаас хөрөнгөжсөнтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ ИХ-ийн 119, 120 дугаар зүйл, 495 дугаар зүйлийн 495.1, 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг анхаарах шаардлагатай байна.

### 3.6. Гэм хор

Иргэний эрх зүйд гэм хорын асуудлыг шийдвэрлэхдээ эхлээд хохирол учирсан байхыг шаардана. Учирсан хохирлыг сэргээх боломжтой, нөгөө талаас мөнгөн хэлбэрээр төлөх байдлаар шийдвэрлэгдэж байна. Анхдагч байдлыг бодит хэрэг дээр нөхөн сэргээнэ гэдэг нь учирсан бодитой гэм хор, хохирол, эвдрэл гэмтлийг бүрмөсөн арилгана гэсэн үг. Харин мөнгөн хэлбэрийн нөхөн олговор олгох гэдэг нь дан ганц тооны аргаар хохирлыг барагдуулж байгаа хэлбэр болдог.<sup>16</sup> Гэм хорын хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хамгийн чухал нь учирсан хохирлыг нөхөн сэргээх боломжгүй нөхцөлд тэнцвэржүүлэх үүднээс дээрх аргыг баримталдаг.

*Гэм хорын маргааныг шийдвэрлэхэд хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- Шүүх хариуцагчийн буруутай ажиллагаанаас учирсан хохирлыг төлүүлэхдээ сэтгэл санааны хохирол нэхэмжилснийг гаргуулж шийдвэрлэсэн нь ИХ-ийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2, 511 дугаар зүйлийн 511.1-д заасантай нийцээгүй, хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Хариуцагчийн гэм буруутай үйлдэл, нэхэмжлэгчид учирсан хохирол, түүний шалтгаант холбоо тогтоогдоогүй байхад нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн нь ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасантай нийцээгүй, эсхүл гэм буруутай нь тогтоогдож байхад нэхэмжлэлийг үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон;
- Даатгалын компани даатгалын гэрээний дагуу төлсөн төлбөрөө гэм буруутай этгээдээс нэхэмжилснийг хэрэглэвэл зохих нарийвчилсан зохицуулалт болох ИХ-ийн 443 дугаар зүйлийн 443.7, Даатгалын тухай хуулийн 8 дугаар 8.7-д заасныг хэрэглээгүй, ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д заасныг хэрэглэсэн;
- Хариуцагч нэхэмжлэгчид өөрийн буруутай үйлдлээс автомашинд учирсан хохирлыг ижил төрлийн автомашин худалдан авч өгч барагдуулсан байхад шүүх зөрүү мөнгийг гаргуулж шийдвэрлэсэн нь ИХ-ийн 510 дугаар зүйлийн 510.1-д заасантай нийцээгүй;
- Шүүх ИХ-ийн 514 дугаар зүйлийн 514.1-д заасан гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно гэсэн хуулийн зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэж хохирлыг багасгасан;
- Шүүх хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нөхөн төлбөр шаардах эрхтэй гэж заасан ИХ-ийн 505 дугаар зүйлийн 505.1, 505.2 дахь зохицуулалтыг буруу тайлбарласан;

<sup>16</sup> Монгол Улсын иргэний хуулийн тайлбар.2010.УБ.,454-р хуудас

- ИХ-ийн 505 дугаар 505.1 дэх хэсгийг баримтлан бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах ёстой байтал 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсгийг баримтлан хэргийг шийдвэрлэсэн;
- Шүүх хэргийг шийдвэрлэхдээ ИХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1, 76.2, 75 дугаар зүйлийн 75.2.4-т заасан хөөн хэлэлцэх хугацааны талаар буруу дүгнэсэн;
- ИХ-ийн 511 дүгээр зүйлийн 511.1, 511.3, 21 дүгээр зүйлийн 21.4-т заасан зохицуулалтууд нь өөр өөр үндэслэлд хамаарч байгааг анхаараагүй хэргийг шийдвэрлэсэн;
- Шүүх гэрээний үүргийн биелэлттэй холбоотой гэм хорын хохирлын шаардлага гаргасныг гэрээний бус үүргийн хохирлын талаар зохицуулсан ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх зохицуулалтуудыг хэрэглэсэн;

ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий үндэслэл болон тусгай төрлийн гэм хорын зохицуулалтыг ялган авч үзээгүй эсхүл гэрээний үүргийн болон үүргийн ерөнхий зохицуулалтуудыг гэм хорын маргаанд хэрэглэсэнтэй холбоотойгоор хууль хэрэглээний алдаа түгээмэл гарсан байна.

Сэтгэл санааны хохирлыг арилгахтай холбоотой маргаанд ИХ-ийн 230, 511 дэх зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтуудыг зөв тайлбарлан хэрэглээгүй зөрчил гарсан.

Гэм хорын улмаас учирсан хохирлыг тооцохдоо ИХ-ийн 505 дугаар зүйлийн “бусдын эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгах”, 510 дугаар зүйлийн “эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах”, 514 дүгээр зүйлийн “хохирогчийн гэм буруу, гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан үзэх” гэсэн хуулийн зохицуулалтуудыг буруу тайлбарлан хэрэглэсэн нийтлэг зөрчлүүд илэрсэн.



### 3.7. Өв залгамжлал

Иргэний хэрэг маргаанд өв залгамжлалын асуудлаар шийдвэрлэж байгаа хэргийн тоо 2012 онд 48 байсан бол 2013 онд 31 хэрэг болж 17 хэргээр буюу өмнөх оноос 55 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргээс харахад өвлөх эрх хуульд заасан үндэслэлээр илүүтэй шийдвэрлэгддэг. Учир нь Монгол Улсад гэрээслэлээр өв залгамжлахтай холбоотой маргаан түгээмэл бус байна.

Улс орнууд өв залгамжлалын тусгайлсан эрх зүйгээр уг харилцааг голчлон зохицуулдаг боловч хөрөнгийн эрх зүй болон гэр бүлийн эрх зүйн хүрээнд гэрлэгчдийн эрхийг хангах нөхцлийг зохих хэмжээнд хамруулах ба ялангуяа, гэрээслэх, өв хүлээн авах зарим харилцааг гэрээний эрх зүйгээр ч тодорхойлох явдал байна.<sup>17</sup>

*Өв залгамжлалын маргааныг шийдвэрлэхэд хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна. Үүнд:*

- ИХ-ийн 515 дугаар зүйлийн 515.1-д заасан “өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө”, 520 дугаар зүйлийн 520.1.1, 520.1.2-д заасан “хууль ёсны өвлөгчийн эрх”, 528 дугаар зүйлийн 528.2, 528.3-д заасан “өв хүлээн авах, хүлээн авахаас татгалзах журам”-ыг ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.5-д заасан хууль ёсны өвлүүлэгчийн бусадтай хамтран өмчлөх эд хөрөнгөөс өвлөгдөх хөрөнгийг зөв тогтоох, эрх зүйн хангалттай дүгнэлт өгөөгүй зэрэг нийтлэг зөрчил илэрчээ.

#### **Жишээ нь:**

##### *1. Хэргийн товч агуулга:*

Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороонд Д-н ээжид 1988 онд Улаанбаатар хотын Гүйцэтгэх захиргаанаас 3 өрөө байр өгчээ. Харин хажуу 1 өрөөг С гэгч улсад мөн өгч 10 жил амьдарч, нас барсан байна. Д нь С-г асарч, халамжилж байсан бөгөөд нас барсны дараа 1 өрөөний ашиглалтын зардлыг төлж, 4 өрөө болгон амьдарч байжээ. 2009 онд С-н амьдарч байсан 1 өрөөний өмчлөх эрхийг өвлөх эрхийн гэрчилгээгээр ач дүү П авсан болохыг олж мэдээд П-ийн өвлөх эрхийн гэрчилгээ болон нотариатын үйлдлийг хүчингүй болгуулахаар шүүхэд ханджээ.

##### *2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

#### Анхан шатны шүүхээс:

<sup>17</sup> Олон улсын хувийн эрх зүй. Т.Мэндсайхан, 2008, УБ., 179-р хуудас

Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.6, 520 дугаар зүйлийн 520.1.1, 531 дүгээр зүйлийн 531.1, 531.2, /1997 оны/ Нотариатын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.9, 32 дугаар зүйлийн 32.5-д зааснаар хариуцагч П, нотариатч Э нарт холбогдох өв залгамжлах эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах, өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдлийг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 105 дугаар зүйлийн 105.1, 528 дугаар зүйлийн 528.2, 528.3, Нотариатын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9, 32 дугаар зүйлийн 32.5-д зааснаар П болон нотариатч Э нарт холбогдох нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж, өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатч Э-ийн үйлдлийг хүчингүй болгож, П-д олгосон 83 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцсон байна.

Хяналтын шатны шүүхээс:

Давж заалдах шатны шүүхийн магадлалын тогтоох хэсэгт “9 дүгээр зүйлийн 9.4.7, 105 дугаар зүйлийн 105.1” гэснийг “515 дугаар зүйлийн 515.5” гэж, “хүчингүй болгосугай гэснийг хүчингүй болгож, Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороонд байрлах 12м.кв нэг өрөө орон сууцыг төрийн өмчлөлд шилжүүлсүгэй” гэж өөрчлөн, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээжээ.

*3. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хууль зүйн шаардлагыг хангаагүй байна.

**А. Хууль хэрэглээний алдаа**

Нэхэмжлэгч Д нь хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх эрхийн аль нь ч үүсээгүй тул өвлөх эрхийн талаар маргах эрхгүй этгээд юм.

Хариуцагч П нь ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1.2-т зааснаар нэг өрөө орон сууцны өмлөгч С-ийн хууль ёсны өвлөгч мөн боловч ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.2-т зааснаар өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хууль заасны дагуу өвийг хүлээн авах талаар ямар нэгэн үйлдэл хийгээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 10 жил өнгөрсөн байх тул ИХ-ийн 528 дугаар зүйлийн 528.3-т зааснаар өвийг хүлээн авахаас татгалзсан гэж үзнэ.

Иймд иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.5-д зааснаар хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөх эрхээ алдсан бол өвлөгдвөл зохих эд хөрөнгө эзэнгүй эд хөрөнгийн нэгэн адил төрийн өмчлөлд шилжих байтал анхан шатны шүүхээс хуулийг буруу хэрэглэж алдаа гаргажээ.

### 3.8. Бусад маргаан

Шүүхээс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой байдаг. Иргэний хэргийн шүүхээс гарсан шийдвэрүүдийг биелүүлэхэд эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа, үнэлгээтэй холбоотой маргаан гарч байна.

2012 оны иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн 15530 хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 10694 хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдсэн бол 2013 онд 15938 шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт 10953 шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдсэн байна.<sup>18</sup>

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргааныг шийдвэрлэхэд хуулийн зүйл, хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн дараах нийтлэг зөрчлүүд байна.*

- Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхдээ ШШГТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.7, 10 дугаар зүйлийн 10.2, 13 дугаар зүйлийн 13.2-г зөрчсөн. Тухайлбал, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглоно. “Шийдвэр гүйцэтгэлийн нэг тойрогт нэг шийдвэр гүйцэтгэгч ажиллана” гэснийг зөрчсөнийг зөв тогтоогоогүй;
- Төлбөрт хураагдсан эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа явуулахтай холбоотой үнэлгээ тогтоох ажиллагаа, худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт шилжүүлэх ажиллагаа ИХ-ийн 48 дугаар зүйлийн 48.1, 177 дугаар зүйлийн 177.1, 177.4-т заасныг ШШГТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4-т заасны алинаар нь нэхэмжлэл гаргаж байгааг тодруулаагүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа мөн хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.5, 36.7, 38 38, 68 дугаар зүйлийн 68.3, 68.5-д заасантай нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаагүй;
- Албадан дуудлага худалдааны процесс ажиллагааг зохицуулсан ИХ-ийн 197 дугаар зүйлийн 197.24, 197.25, 197.26-д заасан журмыг зөрчсөнийг хуулийн бусад заалттай харьцуулан дүгнэлт хийгээгүй; Тухайлбал, дуудлага худалдааны зүйлийг өмчлөх эрх үүссэн эсэхийг ИХ-ийн 178 дугаар зүйлийн 178.1-д заасантай харьцуулан дүгнээгүй;
- Төлбөрт хураагдсан эд хөрөнгө барьцааны зүйл байсан эсэхийг тодруулаагүйгээс ШШГТХ-ийн 54 дугаар зүйлийн 54.2-т заасныг зөрчсөн;

<sup>18</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээ

**Жишээ нь: Сүхбаатар дүүргийн шүүхийн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 353 дугаар шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 245 дугаар магадлал\***

*1. Хэргийн товч агуулга:*

Хан-Уул дүүргийн шүүхийн 2012 оны 122 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн шүүхийн 2012 оны 508 дугаар магадлалаар Н-ээс 164.582.388 төгрөг гаргуулж Б-д олгохоор шийдвэрлэсэн. Энэ хэрэгт битүүмжлэгдсэн эд хөрөнгө болох Баянгол дүүрэгт байрлах 50 дугаар байрны 108 тоотын орон сууцыг хохирогч Б-ийн хохиролд тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлжээ.

Харин нэхэмжлэгчийн зүгээс Баянгол дүүрэг дэх уг орон сууц нь Н-ийн өмчлөлийн хөрөнгө биш учраас уг байрыг хураалгахгүй гэж маргажээ.

*2. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс:

ИХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4.7, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4, 87 дугаар зүйлийн 87.3-д заасныг баримтлан гомдол гаргагч Л, О нарын өмчлөлийн орон сууцыг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас битүүмжилсэн шийдвэрийг хүчингүй болгон битүүмжлэлээс чөлөөлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхээс:

Сүхбаатар дүүргийн шүүхийн шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаажээ.

*3. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ, зөрчлүүд:*

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

**А. Нотлох баримт үнэлэх, тогтоох:**

Эд хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагаа нэг өдөр явагдаж буй нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 36, 38 дугаар зүйлд заасан зарим зохицуулалтад нийцсэн эсэх талаар хоёр шатны шүүх дүгнэлт хийгээгүй.

\* Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү

Тухайлбал, уг хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.5, 36.7-д зааснаар битүүмжилсэн эд хөрөнгийг худалдан борлуулах зорилготой бол хураан авах хугацааг шийдвэр гүйцэтгэгч тогтоох ёстой бөгөөд энэ тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэн эд хөрөнгийг хураан авах, харин тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн бол шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг битүүмжилснийг хүчингүй болгоно. Түүнчлэн, шаардлагатай бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгийг битүүмжлэхийн хамт тухайн эд хөрөнгийг хураан авч болох боловч дээрх актуудад энэхүү шаардлага болон үндэслэлийн талаар дурдаагүй байна.

Эд хөрөнгө битүүмжлэх тогтоолд шийдвэр гүйцэтгэгч “2012 оны 12 дугаар сарын 10-ны дотор орон сууцыг султган чөлөөлж, хүлээлгэн өгөхийг мэдэгдье” гэж заасан атлаа эд хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагааг нэг өдөр хийсэн үйл баримтын талаар анхан болон давж заалдах шатны шүүхээс ач холбогдол бүхий дүгнэлт өгөөгүй байна.

Нийслэлийн давж заалдах шатны шүүх 2012 оны 508 дугаар магадлалд “уг орон сууцыг бусад нэр заасан эд хөрөнгийн хамт хохирогч Б-ээс хулгайлсан мөнгөөр авсан болох нь нотлох баримтуудаар тогтоогдсон” гэж тодорхой заасан тул энэхүү үйл баримтын талаар хийсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4-т заасан “шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин нотлохгүй” гэх зарчмыг зөрчжээ.

Битүүмжлэгдсэн эд хөрөнгийн үнэлгээг ямар үндэслэлээр тогтоосон болох нь ойлгомжгүй байгаа нь ИХШХШТХ-ийн 187 дугаар зүйлийн 187.1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан шаардлагад нийцсэн эсэх талаар дүгнэлт хийгээгүй зэрэг зөрчлүүд илэрчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг оновчтой хэрэглээгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусад хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байхад шүүх энэ талаар эрх зүйн үндэслэлтэй дүгнэлт өгөөгүй нийтлэг алдаа, зөрчлүүд байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 76.1.1, ИХ-ийн 82 дугаар зүйлийн 82.3, 127 дугаар зүйлийн 127.1, 129 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасныг буруу хэрэглэсэн байна.

## Дүгнэлт

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн онцгой үйл ажиллагааны эцсийн үр дүн бөгөөд зөрчигдсэн эрхийн хамгаалалтын илэрхийлэл болсон шүүхийн шийдвэр нь эрх зүйт ёсонд хууль зүйн үндэслэлтэй, шударга ёсонд нийцсэн, процессийн болон материаллаг эрх зүйн зарчим, хэм хэмжээнд зохицсон агуулга, хэлбэртэй байлгах, эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагаанд бүх шатны шүүхээс гарч буй аливаа шийдвэрийг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх учиртай. Энэ бодлогын судалгаанд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарсан алдаа, зөрчлийг илрүүлэх, судлах, тодорхойлох улмаар цаашид анхаарвал зохих асуудлыг гаргаж ирэхийг зорьлоо.

Судалгааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийг хэрэг тус бүрээр судалсан бөгөөд нийтлэг байдлаар дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

*1. Нотлох баримтыг зөв тогтоох, үнэлэх;*

Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт гэж байхгүй боловч шүүгч өөрийн итгэл үнэмшлээр хэрэгт цугларсан баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоодог хэдий ч нотлох баримтын үнэлгээ нь тухайн шүүгчийн мэдлэг, ур чадвараас мөн хамаарна. Иймд хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд нотлох баримтыг тогтоох, үнэлэх, ач холбогдолтойд тооцох асуудалд анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

*2. Нэхэмжлэлийн шаардлага, агуулыг тодруулах, зөв тогтоох;*

Хэрэг, маргааны агуулга, шаардлагыг тодруулах, тогтоох асуудлыг анхааралгүй хэргийг шийдвэрлэх нь шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцэхгүй. Нэхэмжлэлийн агуулга, шаардлагыг үнэн зөв тогтоосноор шүүхийн шийдвэр үнэн, зөв бодитой гарна. Хэрэг, маргааны агуулга, шаардлагыг буруу тогтоож шийдвэрлэснээс давж заалдах болон хяналтын шатанд өөрчлөлт орох, хүчингүй болох үндэслэл болж байна.

*3. Хэргийн оролцогчийн эрх үүргийг хангах;*

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчид болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид шүүх хуралдааны тов мэдэгдэхгүй, эрх үүрэг танилцуулахгүй, шүүх хуралдаанд оролцогчийн эрхийг хангалгүй хэргийг шийдвэрлэж байна. Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч хуралдаанд хүрэлцэн ирэх боломжит хугацааг харгалзан үзээгүй, хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үзэлгүй хэргийг шийдвэрлэсэн зэрэг нийтлэг зөрчлүүд илэрчээ.

*4. Гэрээний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал;*

Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд гэрээтэй холбоотой маргаан ихэнх хувийг эзэлдэг бөгөөд хуулийг зөв тайлбарлах, хэрэглэх асуудлаар нийтлэг зөрчил илэрч байна.

Түүнчлэн хэрэг, маргаанд эрх зүйн ач холбогдол бүхий дүгнэлт хийгээгүй, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоогоогүй, зохигчдын хооронд үүссэн маргааны талаар эрх зүйн дүгнэлт өгөөгүй, нэхэмжлэлийн шаардлагад зааснаас өөр асуудлыг шийдвэрлэсэн зэрэг зөрчлүүд тодорхой хувийг эзлэх тул үүсэх үр дагаврын талаарх хуулийн зохицуулалтуудыг буруу тайлбарлан хэрэглэжээ.

Гэрээний эрх зүйн маргааныг шийдвэрлэсэн шийдвэрээс үзэхэд гэрээг тайлбарлах, гэрээний харилцааг зөв тогтооход анхаарах шаардлагатай байна.

Гэрээний эрх зүйн хэрэг, маргаан нь төлбөр, хүү, алданги гаргуулах асуудалтай холбогддог тул үнийн дүнг үнэн зөв тооцох асуудалд анхааралтай хандах ёстой. Судалгаанаас үзэхэд үнийн дүнг тогтоохдоо нэлээдгүй алдаа гарсан байх бөгөөд энэ нь анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн хэрэгт аль алинд нь энэ төрлийн алдаа гарч байна.

*5. Өмчлөх эрх, хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцох маргааныг хянан шийдвэрлэх асуудал;*

Өмчлөх эрхийн маргааныг хянан шийдвэрлэхэд ИХ-ийн холбогдох зохицуулалтуудыг буруу тайлбарлан хэрэглэх, эрх зүйн зөв дүгнэлт өгөөгүй, хуулийг буруу хэрэглэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн. Тухайлбал, ИХ-ийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийн “хууль бус эзэмшил” гэсэн агуулгыг гаргахтай холбоотой дүгнэлтийг хийхэд ИХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.1, 92 дугаар зүйл, 100 дугаар зүйлийн 100.1, 102 дугаар зүйлийн 102.2 дахь заалтад заасан талаар дүгнэлт өгөөгүй, эсхүл эдгээр заалтын шаардах эрхийг үндэслэл болгон шийдвэрлэсэн нь алдаатай байна.

Түүнчлэн өмчлөх эрхийн маргааныг Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар шийдвэрлэх тул эдгээр хуулийг нэг мөр хэрэглэх, тайлбарлахад цаашид анхаарах нь зүйтэй байна.

*6. Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх асуудал;*

Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл нь хууль, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд үндэслэсэн эсэхийг шалгах, хөөн хэлэлцэх хугацаа, шүүхэд энэ талаар гомдол гаргах хугацаа зэргийг анхааралгүй хэргийг шийдвэрлэсэн зөрчлүүд байна

Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл тус бүрийн онцлог, түүнтэй холбоотой заавал шалгах нөхцлүүдийг Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэн тодруулах, хэрэглэх асуудалд анхаарах шаардлагатай байна.



*7. Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх асуудал;*

Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг тогтоох, энэ тухай ойлголтыг нэр мөр болгох шаардлагатай байна. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийг хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд тооцон шийдвэрлэсэн алдаа, зөрчлүүд байна.

Түүнчлэн хүүхдийн асрамжлагчийг тогтоохдоо хүүхдийн эрх ашигт нийцэхгүй, бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэрийг гаргасан, Гэр бүлийн тухай хуулийг буруу тайлбарлан хэрэглэх зөрчлүүд түгээмэл гарчээ.

*8. Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх асуудал;*

Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд ИХ-ийн эд хөрөнгө буцаан шаардах эрх, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эд хөрөнгийг захиран зарцуулснаас үүсэх хариуцлага, сайн дураараа эсхүл андуурч үүрэг гүйцэтгэснээс үндэслэлгүй хөрөнгөжсөн эд хөрөнгөө шаардах эрхийг хэрэгжүүлэхдээ хууль хэрэглээний алдаа гаргасан.

*9. Гэм хорын маргааныг хянан шийдвэрлэх асуудал*

Иргэний хэргийн шүүхээс гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий үндэслэл болон тусгай төрлийн гэм хорын зохицуулалтыг ялган авч үзээгүй эсхүл гэрээний үүргийн болон үүргийн ерөнхий зохицуулалтуудыг гэм хорын маргаанд хэрэглэсэнтэй холбоотойгоор хууль хэрэглээний алдаа түгээмэл гарсан байна.

Сэтгэл санааны хохирлыг арилгахтай холбоотой маргаанд Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтуудыг зөв тайлбарлан хэрэглээгүй зөрчил гарчээ.

*10. Бусад маргааныг хянан шийдвэрлэх асуудал*

Шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримталж буй хуулийн агуулгыг өөрөөр ойлгох, хуулийн зүйл, хэсгийг зөрүүтэй хэрэглэх, буруу тайлбарлах байдал түгээмэл байна. Тодруулбал, шаардах эрхийн үндэслэлийг буруу тогтоох, гэрээтэй холбоотой маргаанд гэрээний харилцааг буруу тодорхойлох, хөөн хэлэлцэх хугацааг анхаарахгүй орхих, гэрээний үнийн дүнтэй маргаанд тооцооллын алдаа гаргах болон техникийн алдаа гарч байна.

## Санал, зөвлөмж

“Давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн шийдвэрийн үндэслэл, төрөл” сэдэвт бодлогын судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрсэн нийтлэг алдаа, зөрчлийг судалж, тогтоон шүүхийн шийдвэрийг хууль ёсны, үндэслэл бүхий байхад анхаарч дараах санал, зөвлөмжийг гаргаж байна:

### 1. Шүүгчид хэрэгцээтэй сургалт зохион байгуулах;

Судалгааны хүрээнд гарсан нийтлэг алдаа, зөрчлийн талаар нэгдсэн сургалт зохион байгуулахдаа хавсралтад байгаа материалын хүрээнд сургалтын хөтөлбөрийг боловсруулан үр дүнтэй сургалтыг зохион байгуулах шаардагатай байна. Сургалтанд материаллаг болон процессийн хуулийн хэрэглээ, онолын мэдлэг нэмэгдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэрхэн баримтлах талаарх сургалтыг явуулна. Дараах сургалтын сэдвүүдийг санал болгож байна. Үүнд:

#### 1. Процессийн сургалтын чиглэлээр:

- Хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ ХХША-ны журам зөрчигдөхөөс сэргийлэх;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг тогтоох, үнэлэх, шинжлэн судлах;
- Хэрэг, маргааны үйл баримтыг зөв тогтоох;

#### 2. Хууль хэрэглээний сургалтын чиглэлээр:

- Хууль тогтоомжийн хэрэглээ;

#### 3. Хууль зүйн техникийн сургалтын чиглэлээр:

- Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангалттай, зөв тайлбарлах, шүүхийн шийдвэрийн бичилтийн ур чадварыг нэмэгдүүлэх

Түүнчлэн шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий өргөн хүрээний мэдлэг, ур чадвар олгох, хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах хэрэгцээтэй байна. Сургалтын үр дүнд шүүгчид мэргэжил, арга зүй, практикийн ур чадвараа нэмэгдүүлж, цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, зөрчлүүд багасах боломжтой болно.

### 2. Шүүхийн шийдвэрийн алдаа, зөрчлийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх;

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн дээрх зөрчлийн ойлголт, ангилалт одоогоор алга байгаа тул шүүгчид, судлаачдын зүгээс өөрийнхөөрөө тайлбарлах, нэрлэх байдал ажиглагдаж байна. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрч буй зөрчлийн талаар нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна. Ингэснээр шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарах алдааг тодорхойлж, шүүгчдийн

зүгээс энэ төрлийн алдааг гаргахгүй байхад илүүтэй анхаарч, бууруулахад ач холбогдолтой юм.

*3. Хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох;*

Судалгаанаас үзэхэд шүүгчийн ачаалал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой байх тул цаашид хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй, үр нөлөөтэй болгох зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ нь шүүгчдийн гаргаж байгаа энгийн болон процессийн журам зөрчих байдлыг бууруулж, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

*4. Судалгааны ажлыг цаашид үргэлжлүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх;*

Шүүхийн шийдвэр шат шатандаа хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх, шийдвэрийн боловсруулалтыг сайжруулах, хуулийн зохицуулалтыг нэг мөр, зөв хэрэглэх явдлыг хангах, шүүгчдэд зориулсан сургалтын үр нөлөөг дүгнэх зорилгоор энэ судалгааг 2 жил тутам зохион байгуулах саналтай байна. Энэ нь судалгааны хүрээнд санал болгосон чиглэлээр хийгдсэн сургалтын үр дүнг давхар үнэлэх боломжтой болно.

## **Ном зүй**

### **Нэг. Монгол Улсын хууль тогтоомж, тайлбар**

1. Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 1992 он
2. Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он
4. Монгол улсын Иргэний хуулийн тайлбар, 2010 он
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, 2014 он

### **Хоёр. Олон улсын гэрээ, конвенц**

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он
2. Дипломат харилцааны тухай Венийн конвенц, 1961 он

### **Гурав. Ном, сурах бичиг, гарын авлага**

1. Т. Мөнхжаргал, “Монгол Улсын иргэний эрх зүй”, Улаанбаатар хот, 2014 он
2. Т.Мэндсайхан, “Олон Улсын хувийн эрх зүй”, Улаанбаатар хот, 2008 он
3. Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, “Иргэний эрх зүйн ерөнхий анги”, Улаанбаатар хот, 2010 он
4. Б.Буянхишиг “Иргэний эрх зүйн удиртгал”, Улаанбаатар хот, 2012 он
5. Б.Буянхишиг “Үүргийн эрх зүйн ерөнхий анги”, Улаанбаатар хот, 2013 он
6. Б.Буянхишиг “Иргэний эрх зүйн тусгай анги”, Улаанбаатар хот, 2013 он
7. Ж.Оюунтунгалаг “Харьцуулсан Иргэний эрх зүй”, Улаанбаатар хот, 2013 он
8. Монгол Улсын шүүхийн тайлан, Улаанбаатар хот, 2013 он
9. “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл, Улаанбаатар хот, 2014, №1,2

### **Тав. Гадаад эх сурвалж**

1. Robert Hillman “Principles of Contract law”, 2004
2. Joseph W.Glannon “Law of Torts”, 2010
3. Black`s law dictionary, Ninth edition, 2009
4. The Writing Center at GULC, 2003, Identifying and understanding standard of review
5. The Federal Circuit Bar Journal

## **Хавсралт**